5,3,2	Гамшгаас сэргийлэх, аврах, гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах, гамшгийн аюулыг бууруулах, түүний хор уршгийг арилгах үндэсний чадавхийг нэмэгдүүлж, шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлэх, орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр хангах бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	5,3,2,3 Нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэг, Сэлэнгэ аймгийн Баянгол, Дорноговь аймгийн Замын-Үүд сум, Хэнтий аймгийн Бор-Өндөр тосгонд аврах, гал унтраах нэгж шинээр нэмж байгуулна.
5,3,4	Мэргэжлийн хяналтын байгууллагыг орчин үеийн техник, технологи бүхий нэгдсэн лабораторитой болгож, материаллаг баазыг нь бэхжүүлэн, боловсон хүчний чадавхийг сайжруулна.	5,3,4,2 Төв, орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын материаллаг бааз, хүний нөөцийн чадавхийг сайжруулж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авна.
ДҮН		

ХЯНАСАН: ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

БИЕЛЭЛТ ГАРГАСАН: ТЗУХ-ИЙН ХШҮ-НИЙ ТАСГИЙН ДАРГА

ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ /Хэнтий/
килийн эцсийн байдлаар/

Биелэлт	биелэлт %
ГЖҮҮЛСНЭЭР ИРГЭДИЙН АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ	
үүл мэндийн бодлого	
<p>Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийг 19 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулж , аймгийн Засаг даргаар ахлуулсан салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг аймгийн ИТХТ-ийн хурлаар батлуулсан ба 2009 онд зөвлөл 2 удаа хуралдаж ЭМГ-ын ажлын тайлан, ЭМСалбарт хэрэгжиж буй 13 үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг тус тус авч хэлэлцсэн. МУЗГ-ын тогтоолоор 2009 онд шинээр батлагдсан Аймгийн ИТХТ-ийн хурлаар "Сэтгэцийн эрүүл мэнд", "Осол гэмтэл хүчирхийллээс сэргийлэх" хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр, төлөвлөгөөг орон нутгийн онцлогт тохируулан боловсруулж, Орчны эрүүл мэнд дэд хөтөлбөрийг дахин шинэчлэн Аймгийн ИТХТ-ийн хурлаар хэлэлцүүлэн 105 дугаар тогтоолоор батлуулсан. Улсын төсвөөс хуваарилагдсан 8.5 сая төгрөгийг нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээнд зарцуулсан. Сумдын НЭМСЗөвлөлийн гишүүд 2 3 удаа хуралдаж хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн хэрэгжилт, орчны эрүүл мэндийг сайжруулах, айл өрхүүдийг стандартын бохирын цооногтой болгох, нийтийн цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах чиглэлээр хамтарч ажиллах шийдвэрүүдийг гаргаж хэрэгжүүлсэн байна. Сэдэвчилсэн төлөвлөгөөний дагуу 2009 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө боловсруулан батлуулж нийтийг хамарсан арга хэмжээг 48361 хүнд, зорилтот бүлэгт чиглэсэн сургалтыг 12241 хүнд хийж, давхардсан тоогоор 273 байгууллага, аж ахуй нэгжийн 60602 хүн хамрагдсан.</p>	0.5

ЭМГ-ын мэргэжилтнүүд Хэрлэн сумын 20 аж ахуй нэгж байгууллагуудыг хариуцан авч Эрүүл мэндийг дэмжигч байгууллага болгох зорилт тавин хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Үүний дүнд байгууллага, аж ахуй нэгжүүдийн нийтийн үйл ажиллагаанд оролцох идэвхи, оролцоо нэмэгдсэн. Хаш тун хүүхдийн эмнэлэг, Бэрхийн сум дундын эмнэлгүүд "Эрүүл мэндийг дэмжигч" эмнэлгийн болзлыг хангаж өргөмжлөл авсан.ЭМДэмжигч байгууллага шалгаруулах шинэчилсэн болзол, шалгууруудын дагуу уралдаан зарлаж шалгаруулалтанд Хэрлэн сумын төвд Онцгой байдлын газар шалгарсан. Сумдад нийт 44 байгууллагыг шалгаруулж өргөмжилсөн байна. Мөн өрхийн эмнэлгүүдээс 10 өрхөд "Эрүүл мэндээ дээдлэгч өрх" гэрчилгээ олголоо. Бэрх, Цэнхэрмандал, Баян-Адарга сумдад "Соёлч өрх" 8-ыг шалгаруулж олон нийтэд сурталчилсан. Хэрлэн сумын аж ахуйн нэгж, албан байгууллагуудын гадаад орчны өнгө үзэмжийг сайжруулах, ажиллах таатай орчинг бүрдүүлэх, ажлын байранд хөдөлмөрийн түр чадвар алдалтыг бууруулах зорилгоор Хэрлэн сумын Засаг даргатай хамтарч "Тэргүүний тохижилттой байгууллага" шалгаруулах 6 сарын аяны уралдаанд 30 байгууллага оролцсон. Энэ ажлын хүрээнд 8 байгууллага ажилчдын эрүүл ажиллах нөхцлийг сайжруулсан ба орчноо цэцэрлэгжүүлэх, мод тарих, хайс хийх зэрэг ажлыг өргөнөөр зохион байгуулж идэвхи санаачлагатай оролцсон.

0.3

Хэрлэн сумын харьяалалд байгаа эмзэг бүлгийн, гэрийн асаргаанд байгаа хүмүүсийн дунд "Гэрийн сувилахуй" зохион байгуулахад 5 багийн 25 хүн хамрагдсан. аймгийн ХХҮХэлтэстэй хамтран Хэрлэн сумын өрхийн эмнэлгүүдээс эмзэг бүлгийн 38 жирэмсэн эмэгтэйг сонгон авч сувилалд хамруулж, шим тэжээлтэй хоолоор үйлчлэн сургалт явуулсан. Эх барих эмэгтэйчүүдийн болон хүүхдийн эмч нарыг хуваарийн дагуу сард 2 удаа өрхийн эмнэлгүүдэд үзлэг хийлгэн эрсдэлтэй бүлгийн 220 иргэн, 5 хүртэлх насны 188 хүүхдийг хамруулсан. Онцгой хяналт шаардлагатай 64 жирэмсэн эх болон 42 хүүхдийг бүртгэн авч НЭ-ийн поликлиникийн жирэмсний зөвлөгөө өгөх газар болон хүүхдийн кабинетийн эмч хяналт тавьж ажилласан. ЭМСайдын тушаалын дагуу "Нээлттэй хаалганы өдөр"-ийг Хэрлэн сумын түр оршин суугч, бичиг баримтгүй иргэдийн дунд зохион байгуулж, үнэ төлбөргүй нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг, шинжилгээнд хамруулж сургалт сурталчилгааг хийсэн.Эрүүл мэндийн салбарын 217 ахмадыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулж, таяг, нүдний шил олгосон. Батширээт, Биндэр, Баян-Адарга, Баянмөнх, Дархан сумдад нарийн мэргэжлийн эмч нарийн баг ажилллаж үзлэг шинжилгээ хийлээ. Төлбөрийн чадваргүй, амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой болон түр оршин суугч бүртгэлгүй иргэд, оюутан сурагчид, оторт яваа малчид 2982 иргэдэд эмнэлэгийн тусламжийг үнэ төлбөргүй хүргэлээ.

0.3

Аймгийн хэмжээнд 70 гаруй мянган иргэдэд 22 сумын эмнэлэг, сум дундын 2 эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, Хэрлэн суманд өрхийн 3 эмнэлэг эмнэлгийн анхан шатны болон 2 дахь шатны тусламж үйлчилгээг үзүүлж байна. Эрүүл мэндийн эдийн засаг, санхүүжилтийг боловсронгуй болгох зорилгоор ЭМСХ 2 төслөөр анхан шатны ЭМБайгууллага, сум, сум дундын эмнэлгийн санхүүжилтийн аргачлалыг нэг иргэнээр тооцох хувилбарт шилжүүлэх туршилтыг хэрэгжүүлсэн. Туршилтын хүрээнд дараах давуу талууд ажиглагдсан. "Санхүүжилтийг сумдын эмнэлгүүдэд хүн амын тооноос хамааран шударгаар хуваарилах, тусламж үйлчилгээний тэгш байдлыг хангах "Эрүүл мэндийн эрсдэл өндөртэй хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг түлхүү үзүүлэх, "Анхан шатны тусламж үйлчилгээг нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээнд түлхүү чиглүүлэх, "Зардлын үр ашгийг нэмэгдүүлэх хөшүүрэгийг бий болгох, "Санхүүжилтийг үр дүнтэй уялдуудах зэрэг давуу талтай байсан.

0.3

Хувийн хэвшлийн 3 эмнэлэгт сонгон шалгаруулалт явуулж Эрүүл мэндийн даатгалаас санхүүжилт авах эрх олгох аймгийн Засаг даргын 157 дугаар захирамж гаргаж ЭМЯаманд материалыг хүргүүлээ. Хувийн хэвшлийн ортой 3 эмнэлэг, 12 үүдэн эмнэлэг, 12 хувийн эмийн сан ажиллаж байна. ЭМБ уудад үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комисс 4 удаа хуралдаж 1 эмийн бөөний төв, 6 эмийн сан, 3 үүдэн эмнэлэгт шинээр тусгай зөвшөөрөл олголоо.

30

Аймгийн нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, сумын эмнэлэг, өрхийн эмнэлгийн MNS-5095:2001, MNS-5082:2001, MNS-5081:2001, MNS-4621:98, стандартыг баримтлан байгууллага бүрт чанарын алба ажиллаж байна. 2009 оноос аймгийн нэгдсэн эмнэлэгт чанарын менежерийг орон тоогоор ажиллуулж эхэлсэн.

30

Тогтвортой амьжиргаа II төслийн санхүүжилтээр Баян-Адарга сумын ЕБС-ийн спорт заалны дээвэр засварлахад 4.3 сая төгрөг, Норовлин, Галшар суманд чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж 7.4 сая төгрөг, Мөрөн суманд биеийн тамирын гадна талбайн тохижилт, техник хэрэгсэлд 2.4 сая төгрөг, Галшар, Норовлин, Дархан, Батширээт суманд 21.3 сая төгрөгийн өртөгтэй цэцэрлэгт хүрээлэн Баянхутаг сум өөрсдийн хүчээр ЕБС-ийн биеийн тамир, спортын талбайг тохижуулах ажлууд хийгдсэн. Хэрлэн, Батширээт, Галшар, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Баян-Овоо сумдад 21.0 сая төгрөгийн өртөгтэйгээр хүүхдийн тоглоомын талбай тохижуулагдсан нь Хүүхэд өсвөр үеийнхнийг идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх нөхцөл боломж бүрдлээ.

50

Хугацаа болоогүй

<p>Аймгийн Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгад төрөхийн 1.2-р тасгийг байршуулан хүүхэд, төрөх, нярайн тасаг, палатуудыг амьсгалын аппарат, хүчилтөрөгчийн өтгөрүүлэгч, пульсоксиметр, дуслын автомат шахуурга, отсос зэрэг тоног төхөөрөмжөөр иж бүрэн хангаснаар стандартын түвшинд хүрсэн. амьсгалын аппарат, О2-ын өтгөрүүлэгч, ЭМЯамны сайдын 2005 оны 190-р тушаалын дагуу “Эх барихын ноцтой хүндрэлийг хэлэлцэж нэгдсэн зөвлөмж гаргаж сум, өрх, нэгдсэн эмнэлгийн удирдлагад үүрэг болгож, хэрэгжүүлэх ажиллагаа явагдаж байна.ЭМГ-ын даргын 2009-01- р сарын 06 тоот тушаалийн дагуу сум, өрхийн эмч нар болон мэргэжлийн багийн эмч нарын ажлын уялдааг сайжруулан ажилласнаар жирэмсэн эхчүүдэд хяналт сайжирч байна.</p>	50
<p>МУ-ын ЗГ-ын 05 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, биеийн тамир спортоор хичээллэхийн ач холбогдлыг иргэдэд сурталчлах мэдээлэл сурталчилгааны ажлын хүрээнд АЗДТГазар, ЭМГ, БТСГазар хамтран "Эрүүл зан үйлд суралцая" сэдэвт аяны удирдамж гарган бүх сум, байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлэн ажлын байранд хийх дасгалыг зааж сурган, "Идэвхтэй хөдөлгөөн- Зөв хооллолт"- ын талаар сургалт явуулсан. Монголын Үндэсний бөхийн холбоо, УИХ-ын гишүүн дархан аварга Б.Бат-Эрдэнийн санаачлагаар хэрэгжиж байгаа "Нутгийн салхи" хөтөлбөрийн дагуу аймгийн 21 сумын 24 байгууллагын 42 биеийн тамирын багш, арга зүйч нарт сургалт семинар зохион байгуулав. Тус арга хэмжээнд УИХ-ын гишүүн дархан аварга Б.Бат-Эрдэнэ, Монголын Үндэсний бөхийн холбооны тэргүүн Р.Нямдорж, дэд тэргүүн Д.Данзан нар оролцлоо. Сургалтанд БТСГ, БСГ, ЭМГазраас мэдээлэл хийж, шинэчилсэн бүртгэл, санал асуулга явуулж чөлөөт тоглолт зохион байгуулав. Мөн энэ үеэр Жү-до бөхийн багш дасгалжуулагчдын сургалтыг дархан аварга удирдаж явуулав.</p>	30
<p>Тогтвортой амьжиргаа II төслийн санхүүжилтээр Баян-Адарга сумын ЕБС-ийн спорт заалны дээвэр засварлахад 4.3 сая төгрөг, Норовлин, Галшар суманд чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж 7.4 сая төгрөг, Мөрөн суманд биеийн тамирын гадна талбайн тохижилт, техник хэрэгсэлд 2.4 сая төгрөг, Галшар, Норовлин, Дархан, Батширээт суманд 21.3 сая төгрөгийн өртөгтэй цэцэрлэгт хүрээлэн Баянхутаг сум өөрсдийн хүчээр ЕБС-ийн биеийн тамир, спортын талбайг тохижуулах ажлууд хийгдсэн. Хэрлэн, Батширээт, Галшар, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Баян-Овоо сумдад 21.0 сая төгрөгийн өртөгтэйгөөр хүүхдийн тоглоомын талбай тохижуулагдсан нь Хүүхэд өсвөр үеийнхнийг идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх нөхцөл боломж бүрдлээ.</p>	50
<p>Тэмбүү, ХДХВ илрүүлэх шинжилгээг хяналтанд орсон 1636 жирэмсэнд 28-32 долоо хоногтойд хийсэн. Өрх, сумдын эх баригч бага эмч нарт сургалт хийж өрхийн 10 эмч, 30 эх баригч хамруулсан.</p>	30
<p>ювсрол, соёл шинжлэх ухааны бодлого</p>	
<p>2009-2010 оны хичээлийн жилд хувилбарт сургалтанд нийт 1090 хүүхэд хамрагдсанаас 26 гэр цэцэрлэгийн 50 бүлэг ажиллаж 539 хүүхдийг хамруулснаар СӨБ-ын хамран сургалт 78,5%-д хүрч Мянганы хөгжлийн зорилт, аймгийн засаг даргын БСШУ-ны сайдтай байгуулсан гэрээний биелэлтийг бүрэн хангалаа</p>	30

Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 6 дугаар бүлэгт заасны дагуу өмчийн хэлбэр үл харгалзан цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох нормативт зардлыг олгож байна.2008-2009 оны хичээлийн жилд 4112 хүүхдэд 829.5 сая төгрөг олгосон байна

100

Сумдын засаг дарга нартай гэрээ байгуулан ажилласны үр дүнд 1-р ангиас сургууль завсардалт гаргаагүй ажилласнаар бага боловсролын хамран сургалт 99.0 хувьд хүрсэн. 2009-2010 оны хичээлийн жилд бага боловсролын хамран сургалт 97%-тай байна

100

Багш нарын мэргэжлийг дээшлүүлэх нь багшийн хөгжлийн цаашилбал аймгийн боловсролын хөгжлийн тулгуур гэж үзэн хөрөнгө санхүүгийн бололцоогооо дайчлан БСШУЯ, МУБИС, олон улсын төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллаж 6,5 сая төгрөг зарцуулж, улсын хэмжээний сургалтанд 130, бүсийн сургалтанд 852, аймаг, орон нутгийн хэмжээний сургалтанд давхардсан тоогоор 912 багшийг хамруулж, мэргэжил боловсролыг нь дээшлүүлээд байна. Мөн удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалтанд 125 хүн хамрагдаад байна. Бүх сургууль, цэцэрлэгийн багш, удирдах ажилтны үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ хийж, сурагчдын сурлагын аймгийн дундаж үзүүлэлтийг түүвэрчилсэн байдлаар тогтоосон. Багшийн мэргэжлийн үнэлэмж, нэр хүндийг дээшлүүлж, багш, боловсролын байгууллагын удирдах ажилтны цалин, хангамжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд уран бүтээлийн тайлан, үзэсгэлэн, бүтээл туурвил, уралдаан тэмцээнд оролцох зардлыг орон нутгийн нөөц бололцоог дайчлан дэмжлэг үзүүлж байна. Үүнд: Боловсролын салбарт үр бүтээлтэй ажилласан 37 багш төрийн дээд одон медалиар шагнагдлаа.Аймгийн болон улсын чанартай уралдаан тэмцээнүүдэд амжилттай оролцсон багш нарт сургуулиуд өөрсдийн дотоод журмын дагуу урамшуулал олгож байгаагаас гадна улирлын үр дүнгийн гэрээний мөнгийг бүх сургуулиудад олгосноор үр бүтээлтэй ажилласан багш, удирдах ажилтнуудыг урамшуулах боломжтой боллоо.Мөн аймгийн Засаг даргын санаачлагаар багшийн ажлыг бодитой үнэлэх, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 2010 оноос эхлэн жил бүр аймгийн "Тэргүүний багш" шалгаруулахаар болж, журмын төслийг хэлэлцэж байна.Мөн БСШУ-ны сайдын 2010 оны 21 дүгээр тушаалын дагуу боловсрол, соёл ,шинжлэх ухааны салбарын байгууллагуудын албан хаагчдыг орон сууцны зээлд хамруулах хуваарийн дагуу хуваарилалтыг хийж байна. Манай аймагт нийт 57 орон сууцны хуваарилалт ирсэн байна.

70

Электрон сургалтын арга зүй нэвтрүүлэх сургалтыг зохион байгуулж сургууль бүрт сургагч багш бэлтгэснээр тэд өөрсдийн сургуулийн багш нарт сургалт явуулан электрон сургалтын арга зүйг сургалтандаа амжилттай нэвтрүүлж байна. Сургуулиуд бүгд өөрсдийн нөөц бололцоо, олон улсын төсөл хөтөлбөр, хандив тусламжаар багш нарын өрөөг тохижуулж байгаагаас гадна аймгийн төвийн 4 сургууль, сумдын 4 сургууль интернетэд холбогдон багш нар цаг үетэй холбогдолтой мэдээ, мэдээллийг олж авахын зэрэгцээ мэдээдэл харилцааны технологи ашиглан мэргэжлээ дээшлүүлж байна. Аймагт хэрэгжиж байгаа ДЗОУБ, Тогтвортой амжиргаа төсөл, ОНЗДХөтөлбөр, ХЯБХөтөлбөр зэргээс сандал, ширээ, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн, тохижилт зэрэгт нийт 237.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Хан Хэнтий ЦС-ийн 40 жилийн ойд зориулан Аймгийн Засаг дарга багшийн хөгжлийн төвд зориулан иж бүрэн компьютерын кабинет, МСҮТ-ийн ойд зориулан 1ш компьютер хандивлав. БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар Тэмүүжин ЦС-д 20, Хэрлэн -1, 4-р сургуулиудад тус бүр 10 компьютер хуваарилагдсан ба Ерөнхий сайд Цэнхэрмандал сумын сургуулийн багшийн хөгжлийн төвд 10 ш компьютер өгсөн.

70

2009 оны жилийн эцсийн байдлаар бичиг үсэг үл мэдэгч хүн амын аймгийн нийт хүн амд эзлэх хувь нь 1,5 байгаа нь өмнөх оноос 0,5 хувиар буурсан. Бичиг үсгийн боловсрол олгох сургалтанд нийт 307 хүн хамрагдсан бөгөөд бичиг үсэг үл мэдэгч 163 хүнийг бичиг үсэгтэй болгосон. Тус сургалтын үйл ажиллагаанд ОУ-ын төсөл хөтөлбөрийн хүрээнд нийт 3 сая төгрөг зарцуулсан. Бичиг үсэг үл мэдэгчдийн дийлэнх хувийг насанд хүрэгчид эзэлдэг тул сургалтанд хамруулахад бэрхшээл учирдаг. Тиймээс ШШГАЛбанд хүмүүжиж байгаа 21 залуучуудад бичиг үсгийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулсан.

50

Аймгийн хэмжээнд 9 сургууль цайны газартай бөгөөд түүгээр дамжуулан үдийн цайгаар үйлчилж байна. Тогтвортой амжиргаа-2 төслөөр Баянмөнх, Норовлин сумдын сургуулийн гал тогооны тоног төхөөрөмжийг 6,1 сая төгрөгөөр, Өмнөдэлгэр сумын сургуулийн дотуур байрны гал тогооны тоног төхөөрөмжийг 3,7 сая төгрөгөөр тус тус шинэчиллээ. 2010 онд хичээлийн жилд ХЯБХ-ийн хүрээнд 6 цэцэрлэгт гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлэхээр болоод байна.

50

	Хугацаа болоогүй
<p>Аймгийн хэмжээнд 26 сургууль сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаа явуулж байгаагаас 24 нь дотуур байртай бөгөөд Бор-өндөр хотод үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус өмчийн 2 сургууль дотуур байргүй байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Бор-Өндөр ЦС-ийн дотуур байрны өргөтгөлийг 479,8 сая төгрөгөөр барьж 2010 онд ашиглалтанд оруулснаар аймгийн хэмжээнд төрийн өмчийн сургуулиуд 100% дотуур байртай болох юм. Одоогийн байдлаар 4 сумын дотуур байр хангалтгүй байна. 2009 онд боловсролын салбарт улсын төсвийн болон ОУ-ын төсөл хөтөлбөрийн хүрээнд нийт 3.113.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээс 721,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт нь дотуур байр барих, засварлахад зарцуулагдаж байна. Үүнд: Улсын болон ОУ-ын төсөл, хөтөлбөрүүдийн хөрөнгө оруулалтаар ХБУ тосгоны сургуулийн дотуур байрны барилгыг шинээр барьж, Өмнөдэлгэр сумын ЕБС-ийн хичээлийн байр болон дотуур байрны барилгын их засвар, Хэрлэн 1-р сургуулийн дотуур байрны их засвар, Дэлгэрхаан сумын сургуулийн дотуур байр, Цэнхэрмандал, Баянхутаг сумдын сургуулийн дотуур байрны тохижилт, засвар зэрэг байна.</p>	50
<p>Өндөрхаан хотын усан санг түшиглэн ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын хичээлийн хөтөлбөрт усанд сэлэлтийн төрлийг оруулахаар бэлтгэл ажлаа хангаж байгаа бөгөөд усан спортын холбооноос багш томилуулаад байна.Одоогийн байдлаар усан сан засварлагдаж, ашиглалтанд ороогүй байгаа тул хичээл явагдах боломжгүй байна.</p>	30

<p>Хөдөлмөрийн зах зээлийг судалж, эрэлт, нийлүүлэлтэд тохирсон мэргэжилтэй ажилтан бэлтгэх төлөвлөлтийг хийж бэлтгэл ажлыг хангаж байна. Үүнд: Мэдээлэл зүйн кабинетийг шинэчлэн 40ш компьютер авч дотоод сүлжээг интернэтэд холбосон ба цаашид шилэн кабелиар холбох ажил хийгдэж байна. Оёдлын мастерийн газарт ЮНЕСКО-ийн төслөөр АНУ-ын "Зенгерн" фермийн 3 машин суурилуулж, Дэлхийн зөн ОУБ-ын төслөөр 10.0\$ -ын багаж авч, барилгын мастерын газрыг өргөтгөлөө. Гүн өрмийн 2 худаг гаргуулан худгийн барилга барьснаар ногооны газар, жимсний цэцэрлэг, цэцэрлэгт хүрээлэнгээ услах арчлах бүрэн боломжтой болсон. Нарийн боов, блокны цех ажиллуулж сургуульд 9.2 сая төгрөгийн ашиг орууллаа.Өмнөдэлгэр сумын ЕБС-ийн 12 жилийн сургуулийн багшлах боловсон хүчин, материаллаг баазад түшиглэн мэргэжлийн сургалттай анги нээж орон нутагт шаардлагатай байгаа малчин фермер, ногоочин, газар тариаланч, трактор комбайнчин, автын жолооч зэрэг мэргэжлүүдээр төрөлжсөн анги нээн ажиллуулах талаар судалж байна.</p>	30
<p>БСШУЯ-наас дэвшүүлэн тавьсан "Боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах" зорилт, Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2008 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан Аймгийн Засаг даргын 2009-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэргийг хэрэгжүүлэх зорилгоор МУИС-ийн лицей байгуулахаар бэлтгэл ажил хийгдэж, байрны асуудлыг шийдвэрлээд байна. МУС 1-ийн барилгад нийт 3,5 тэр оум төгрөгийн хөрөнгө оруулалт батлагдаж барилгын ажил эхлээд байна.</p>	30 30
<p>2009 онд Дэлгэрхаан сумын соёл, спортын төв, Баян-Овоо сумын соёлын төвийн барилгыг гүйцээх төлөвлөгөөтэй ажилласнаас Дэлгэрхаан сумын соёл, спортын төвийн барилгыг дуусгаж хүлээлгэж өгч 12.2 сая төгрөгийн номын сангийн ширээ сандал, үзэгчдийн сандлаар хангагдлаа. Тогтвортой амьжиргаа-2 төслийн хүрээнд Биндэр сумын соёлын төвийн заал, бүжгийн танхимд 4,8 сая төг, Дадал сумын соёлын төвийн музейн дээврийн засварт 5,0 сая төгрөгийн барилга угсралтын ажил хийгдлээ.</p>	50
<p>Баян-Адарга, Биндэр, Хурх, Өмнөдэлгэр сумдын номын санч нар аймгийн төв номын сантай гэрээ хийсний үндсэн дээр хөдөөгийн хүн амд "Явуулын номын сан " үйлчлүүлэх арга хэмжээ авч нийт 600 гаруй номоор үйлчиллээ. -22 соёлын төвийн номын сан нь явуулын номын сангийн үйлчилгээгээр 148 удаа үзэсгэлэн, соёл олон нийтийн ажил зохион байгуулж нийт 700 иргэдэд үйлчилсэн байна.</p>	30

"Түүх соёлын үл хөдлөх дурсгалт газрыг сэргээн засварлах" хөтөлбөрийн хүрээнд Монгол улсын Засгийн газрын 2008 оны 175 дугаар тогтоолын дагуу Улсын хамгаалалтанд байгаа Өмнөдэлгэр, Батширээт, Цэцэн ханы ордны цогцолборын хамгаалалтын бүс, солбилцлын цэг, координатыг тогтоосон тухай Засгийн газрын тогтоол гарлаа. Мөн Баян-Адарга сумын "Дуурлиг нарс"-ны Хүннүгийн булшинд хайгуул малтлага хийхээр зөвшөөрөл авсан Мон Солонгос эрдэм шинжилгээний багийн гишүүд 8 сарын 25 ныг дуустал хугацаанд ажиллалаа.

зээл, хөдөлмөр эрхлэлтийн бодлого

2009 онд нийт 363 өрхийг ядуурлаас гаргахад бодит дэмжлэг үзүүллээ. “Нэг өрх-нэгээс доошгүй ажлын байр” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 4 сумын 4 өрхийн 12 иргэнд ажлын байрны төслийг санхүүжүүлэх зорилгоор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 14.5 сая төгрөг олгосон. Аймгийн хэмжээнд "Тогтвортой амжиргаа-2" төслийн шугамаар гамшигт нэрвэгдэж малгүй болсон 8 сумын 420 өрхөд 300.6 сая төгрөгийн 10020 толгой мал олгов. Италийн төрийн бус Аифо байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжиж байгаа "Тэгш дүүрэн" хөтөлбөрийн хүрээнд 4 сумын хөгжлийн бэрхшээлтэй болон ядуу 35 өрхийг малжуулах төсөлд хамрууллаа.

<p>Аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 2008-2009 оны хичээлийн жилд мужаан,сантехник,өрлөгчин,тогооч нарийн боовчин,барилгын засал чимэглэл,жолооч, оёдлын мэргэжлээр 904 хүүхэд залуучууд суралцаж 247 суралцагч төгссөн.Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсээс 2009 онд агропарк ногоочны мэргэжлээр 99,оёдол 57,касс худалдагч 160,сантехникч 25,гар урлал 25,аж ахуй эрхлэлтийн сургалт 36,байгууллага дээрх барилгын сургалт 20,тогооч 55,үсчин 40,өрлөгчин мэргэжлээр 25 нийт 542 хүнийг эрэлтэд тулгуурласан мэргэжил олгох сургалтанд хамруулж "Эрхийн бичиг" олгосон..</p>	30
<p>2007-2008 оны хичээлийн жилд 500 суралцагч суралцаж байсан бол тус сургууль нь жил бүр 300-аас доошгүй суралцагч элсүүлэн сургахаас гадна хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг судлан барилгын сантехник, гагнуур, нарийн боов, худалдааны газрын үндсэн ажилтны ангид элсүүлэх хүүхдийн тоог нэмэгдүүлэх бодлого барин ажилласнаар 2009-2010 оны хичээлийн жилд 420 суудалтай хичээлийн байранд 944 суралцагч болсон байна. МСҮТ-д суралцах хүүхдийн тоо өсч байгаа нь төрөөс сар бүр өгдөг тэтгэмж болон төгсөгч нар нь мэргэжилтэй боловсон хүчин болж, ажлын байраар хангагдах бүрэн боломжтой болсонтой холбоотой байна.</p>	50
<p>ийн хамгааллын бодлого</p>	

НХХЯ-тай хамтран зохион байгуулсан нийгмийн ажилтнаар мэргэшүүлэх 1,2,3 дахь шатны сургалтыг зохион байгуулж 22 сум тосгоны 29 хүн нийгмийн ажилтнаар бэлтгэгдсэн. Нийгмийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтонд ёс зүйн хэм хэмжээний талаар тусгаж өгөн ажиллаж байна.

30

Нийгмийн халамжийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх ажлын хүрээнд 2009 оноос 22 сум, хот, тосгонд 29 мэргэшсэн нийгмийн ажилтан ажиллаж байна. Нийгмийн хамгааллын үйлчилгээг иргэдэд хүнд сурталгүй, ил тод, шуурхай хүргэх ажлыг сайжруулах зорилгоор аймаг, сумын ЗДТГ болон Ажил олгогч эздийн холбоотой хамтран "Ажлын байр-2009" ажилд зуучлах үйлчилгээ, үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, иргэдийг гарын авлага, холбогдох бусад материалуудаар ханган ажиллаж байна. Халамжийн үйлчилгээтэй холбоотой иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл, гомдлын дагуу сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүнг үндэслэн холбогдох арга хэмжээ авч ажиллаж байна.

30

Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр Засгийн газраас батлагдаагүй байна. 2009 оны 12 сард НХХЯ-аас ядуурлын түвшин тогтоох туршилтын судалгааг Хэрлэн, Мөрөн, Жаргалтхаан сумын 45 өрхөөс авсан.

30

"Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр"-ийг эхлүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Засгийн газраас уг хөтөлбөрийг баталж гаргаагүй байна.

10

Монгол Улсын Засгийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан 50000 өрхийг ядуурлаас гаргах зорилтын хүрээнд 2009 онд аймгийн хэмжээнд 363 өрхийг ядуурлаас гаргах зорилт дэвшүүлэн тавьж сумдад хуваарилан хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.Энэхүү ажлын хүрээнд ядуурлаас гаргах шаардлагатай өрхийн дэлгэрэнгүй судалгааг сумдаас гаргуулан авч мэдээллийн санг бүрдүүлээд байна.

30

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 50000 өрхийг ядуурлаас гаргах зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2009 онд 363 өрхийг ядуурлаас гаргахад бодит дэмжлэг үзүүлсэн. Дээрх ажлыг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус хувийн хэвшлийн 5 байгууллагатай гэрээгээр хамтран ажилласан. Мөн сум бүрт иргэдийг ядуурлаас гаргах, нийгмийн халамжийн үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэх зорилго бүхий "Амжиргааг дэмжих зөвлөл"-ийг байгуулан ажиллуулж байна.

30

"Амьдрах ухааны чадварууд" сургалтанд нийгмийн ажилтан, багш сурагчдын 50 орчим хүмүүс хамрагдаж 11 цуврал хичээлээр, МУБИС-ийн багш

50

"Хүслэн" Хүүхдийн оролцоог удирдах зөвлөлөөс "Ирээдүйн цонх" чуулганыг 2-р сард "Хүүхдийн чөлөөт цаг" сэдвийн хүрээнд зохион байгуулж, уриалга гаргасан. "Хүүхэд хүүхэддээ", "Амьдрах ухааны чадварууд", Хүүхэд хүмүүжүүлэх зэрэг аргууд, Хүүхдийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг сургалтуудыг насанд хүрэгчид, төрийн албан хаагчид, багш нар, хамтарсан багийн гишүүдэд 9 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 500 орчим хүнийг хамруулсан. Байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, түүх соёлын дурсгалтай танилцах, эх оронч үзэл төлөвшүүлэх, бие дааж амьдрах арга

50

"Хөх Монголын хөвгүүд"- ийн сарын аяны хүрээнд "Архидалтын эсрэг", "Хорт зуршлын эсрэг" сургалтыг аймгийн ерөнхий боловсролын сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн дунд зохион байгуулж 120 гаруй хүүхэд, "Хорт зуршлаас сэргийлье" сургалтыг Хэрлэн сумын 5 сургуулийн 150 орчим хүүхдэд зохион байгуулж, сургалтаар гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, архи тамхины хор уршиг, найз нөхдийн уруу таталтаас өөрийгөө хэрхэн сэргийлэх, бие дааж шийдвэр гаргах чадвар зэрэгт суралцуулсан. "Сан бүрд" олон сувгийн ТВ-ээр 40 төрлийн нэвтрүүлэг үүний дотор 4 шууд нэвтрүүлгийг бэлтгэн явуулж, гэдэсний халдварт өвчнөөс сэргийлэх, гараа хэрхэн угаах чиглэлээр үе тэнгийн 190 сургагчийг бэлтгэсэн. Мөн ХХҮХ-тэй хамтран ХДХВ/ДОХ/БЗДХ өвчний талаар ахлах ангийн 35 сурагчид сургалт явуулж, энэ чиглэлийн асуулт хариултын танин мэдэх уралдаан зохион байгуулж 300 гаруй сурагчид оролцсон.

50

Аймгийн Засаг даргын 2009.4.07 ны өдрийн 88 тоот захирамжаар Хүүхдийн нэгдсэн зөвлөлийг шинэчлэн баталсан. Оролцооны байгууллагуудын ажиллах зарчим, зохион байгуулалт, гишүүдээ идэвхжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх, хүнд нөхцөлд байгаа хүүхдүүдийг хамруулах, хүүхдүүд орон нутгийн шийдвэр гаргагчдад хэрхэн нөлөөлөх, өөрсдийн шийдвэрээ үйл ажиллагаанд хэрхэн тусгуулах чиглэлээр арга зүйн зөвлөгөө өглөө. "Хүнд нөхцөл дэх хүүхэд" сэдвийн дор хүүхдийн чуулганыг зохион байгуулж, хүүхдийн өмнө тулгамдаж буй асуудлаар 5 хэсэгт хуваагдан 2 өдөр чуулж, чуулганд 178 хүүхэд, насанд хүрэгчид оролцлоо.Хүүхдээс ирсэн саналыг үндэслэн Боловсролын тухай хуулийн 40.7, БСШУ-ны сайдын 2008 оны 98 тоот тушаал хэрэгжихгүй байгаатай холбогдуулан аймгийн Засаг дарга шийдвэр гаргах түвшин дэх хүүхдийн байгууллагын удирдлагуудтай уулзан аливаа уралдаан тэмцээнд оролцож буй хүүхдээс мөнгө татахгүй байх, хууль дүрмийг биелүүлж ажиллах талаар үүрэг даалгавар өглөө.

50

ЧЭЭР ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗОРИЛТ

йн засаг, санхүүгийн бодлого

Аймгийн ДНБ-ний өсөлт 2008 онд 1,2 хувь байгаа боловч цаашид уул, уурхай, барилга, боловсруулах аж үйлдвэр, худалдаа, үйлчилгээний салбарын үйл ажиллагааны өргөжилт, жонш, төмрийн хүдэр, нүүрс зэрэг эрдэс түүхий эдийн олборлолтын өсөлтөөс шалтгаалан эдийн засгийн бодит өсөлт 2009 онд урьдчилсан байдлаар 1.5-2.0 хувь болж өсөх хандлагатай байна.

30

Монгол улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Монгол Улсыг хөгжүүлэх цогц бодлого батлагдаж түүний хэрэгжилтийг шалгах шалгуур 67 үзүүлэлтийг 2008 оны 13 дугаар тогтоолоор батлан мөрдөж байна. Үүнтэй үялдуулан аймаг өөрийн онцлог

30

Ажилгүйдэл ядуурлыг бууруулах зорилтын хүрээнд 2009 оны эхний хагас жилийн байдлаар ХААН, Монгол шуудан, Хас банкаар дамжуулан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 184 иргэнд 110.0 сая төгрөгийн бичил зээл олгож шинээр 104 ажлын байр бий болгоод байна. Мөн нийтийг хамарсан ажил, ажил олгогчийн урамшуулал, сургалт, зөвөлгөө өгөх, үйлчилгээнд давхардсан тоогоор 1126 хүнд 69643,2 мянган төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулаад байна.

30

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 624.4 сая төгрөгийн, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 113.3 сая төгрөгийн, зүүн бүсийн "Бүс нутгийн хөрөнгө оруулалтыг дэмжих" хөрөнгө оруулалтаар 366.5 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олголоо. Орон нутагт хэрэгжиж буй засаглалыг дэмжих , ядуурлыг бууруулах хөтөлбөрүүдтэй хамтран ажиллаж орон нутгийн төсвөөс 38.0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлээд байна.

50

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2009 оны 20 дугаар тогтоолоор Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийг шинэчлэн байгуулсан. Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж байна. Аймгийн

30

<p>Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас зохион байгуулсан "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй" сургалтанд хамрагдсан. 3 дугаар сарын 15-ны өдөр буюу Олон улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдөрт зориулан аймгийн банкны бүхий л салбаруудад хэрэглэгчдэд мэдлэг, мэдээлэл олгох, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээгээ сурталчилах ажлыг зохион байгуулж Дөлгөөн Хэрлэн FM-106.2 радиогоор мэдээлэл хийлээ.</p>	30
<p>2005 оны Засгийн газрын 127-р тогтоолоор батлагдсан тохирлын үнэлгээнд заавал хамрагдах бүтээгдэхүүн үйлчилгээний жагсаалтад орсон бүтээгдэхүүнд Стандартчилал, хэмжилзүйн хэлтсийн нэгдсэн лаборатори сорилт шинжилгээ явуулж, шинжээчийн дүгнэлт гаргуулж нэг нэрийн 1 бүтээгдэхүүн, 87 үйлчилгээнд тохирлын үнэлгээг хийж гэрчилгээ олгосон. Аймгийн хэмжээнд сорилт хэмжилзүйн үйлчилгээг нэг цэгийн зарчимд шилжүүлснээр Стандартчилал, хэмжилзүйн хэлтсийн харъяанд нэгдсэн лаборатори болон хэмжилзүйн лаборатори нь үйл ажиллагаагаа явуулж байна. 2009 онд 1850 дээжинд 3150 үзүүлэлтээр сорилт шинжилгээ хийж 2627 ш хэмжих хэрэгслийг баталгаажуулав.</p>	100
<p>Идвэржүүлэх бодлого</p>	
<p>Тус аймагт уул уурхайн үйлдвэрийг түшиглэсэн барилгын материалын үйлдвэр байгуулагдаагүй. 2010 оноос Мөрөнгийн шохойны үйлдвэрийг түшиглэн Цементийн үйлдвэр байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлыг хийхээр төлөвлөж байна.</p>	хугацаа болоогүй
<p>Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран аймгийг бүсчилэн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх судалгааг хийж дуусган ерөнхий чиглэлийг гаргасан бөгөөд улмаар орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлийг боловсруулан аймгийн Засаг даргын зөвлөл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр оруулж хэлэлцүүлэхэд бэлэн болоод байна. Мөн "Монгол улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр"-ийг орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж байна.</p>	50
<p>Трассад ойр орших багийн төв, хот айл, суурингийн талаархи судалгааг гарган хүргүүлсэн. Энэ судалгааны хүрээнд Эрдэс баялаг эрчим хүчний яам, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Хэрлэн сумын 8-р баг Тахилгат тосгоныг төвлөрсөн эрчим хүчинд холбохоор болсон. Хэрлэн сумаас зүүн тийш ногоочидруу тавигдсан 3 км 0.6 кВ-тын шугамаас залгуулан 2,5 км цахилгаан дамжуулах агаарын шугамыг барьж дуусган нийтдээ орон нутгийн</p>	50

<p>Хэнтий намрын баяр -2009 өдөрлөгийг 2009 оны 9 дүгээр сард Өндөрхаан хотноо зохион байгуулж нэг суурин-нэг бүтээгдэхүүн шилдэг бүтээгдэхүүнийг 9 нэр төрлөөр шалгарууллаа. Өдөрлөгийн арга хэмжээнд нийт 16 сум, 3 тосгоны 300-гаад үйлдвэрлэгч, бизнес эрхлэгч, ногоочид оролцож 35 нэр төрлийн 79,0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. "Хэнтий намрын баяр -2009" өдөрлөгт амжилттай оролцсон үйлдвэрлэгчдийг мөн Дэлхийн байгаль хамгаалах сангийн "Онон балжийн сав газрыг хамгаалах" төсөлтэй хамтран Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Баян-адрага, Дадал, Баян-Овоо, Цэнхэрмандал зэрэг 7 сумын 20 аж ахуйн нэгж, иргэнийг хамруулж Улаанбаатар хотод зохион байгуулагдсан "Намрын баяр 2009" үзэсгэлэнд амжилттай оролцсон.</p>	100
<p>байгуулж 14 сумын 5314 сурагчид хамрагдан 7074 л сүүг малчдаас шууд нийлүүлэн мал эмнэлгийн шинжилгээнд хамруулан сурагчдад өгсөн. Батширээт суманд "Сүү" ХК-ний салбар хоногт 10 тн сүү боловсруулах цех, Биндэр суманд хоногт 1 тн сүү боловсруулах цехийг ашиглалтанд оруулан үйл ажиллагаагаа явуулж байна. Дадал, Хэрлэн сумдад Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Сүү" төслийн хүрээнд 5.9 сая төгрөгийн өртөгтэй 1 жилийн дараагаас эхлэн 2 жилийн хугацаанд хүүгүй, эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах тоног төхөөрөмжийг суурилуулан үйл ажиллагаагаа явуулж байна. Улсын төсвийн төвлөрсөн хөрөнгө оруулалтаар Өндөрхаан хотод баригдаж буй хоногт 2 тн сүү боловсруулах хүчин чадалтай сүүний үйлдвэр нь барилгын засвар тохижилтын ажил дуусч, тоног төхөөрөмжийн угсралт хийгдэж байна. Хэрлэн суманд "Мах экспорт" ХХК-ний салбар хоногт 120 бод, 250-300 бог нядлаж боловсруулах хүчин чадалтай махны анхан шатны боловсруулалт хийх үйлдвэрийн барилга болон тоног төхөөрөмжийн угсралтын ажил дуусч, үйл ажиллагаа нь 2009 оны 8-р сараас эхэлсэн. Тус үйлдвэр экспортод нийлүүлэх 250</p>	30
<p>Батширээт суманд "Сүү" ХК-ний салбар хоногт 10 тн сүү боловсруулах цех, Биндэр суманд хоногт 1 тн сүү боловсруулах цехийг ашиглалтанд оруулан үйл ажиллагаагаа явуулж байна. Дадал, Хэрлэн сумдад Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Сүү" төслийн хүрээнд 5.9 сая төгрөгийн өртөгтэй 1 жилийн дараагаас эхлэн 2 жилийн хугацаанд хүүгүй, эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах тоног төхөөрөмжийг суурилуулан үйл ажиллагаагаа явуулж байна. Улсын төсвийн төвлөрсөн хөрөнгө оруулалтаар Өндөрхаан хотод баригдаж буй хоногт 2 тн сүү боловсруулах хүчин чадалтай сүүний үйлдвэр нь барилгын засвар тохижилтын ажил дуусч, тоног төхөөрөмжийн угсралт хийгдэж байна.</p>	30
<p>Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа 4 аж ахуйн нэгж Хэнтий аймгийн хэмжээнд ажиллаж байна. Хэрлэн сумын төвд ажиллаж байгаа 2 аж ахуйн нэгж нь боловсруулсан сүү, тараг үйлдвэрлэн савлаж борлуулж байгаа ба Батширээт суманд 2009 оны 7 сард байгуулагдсан сүү боловсруулах цех нь мал бүхий иргэдээс хоногт 3,0 тн сүү худалдан авч, стандартын шаардлага хангасан цөцгийн тос, аарц үйлдвэрлэж, Сүү ХК-д нийлүүлж байна. Малчид, фермерүүдийн сүүг нэгдсэн байдлаар цуглуулан хөргөж, боловсруулан хоногт 2 тн сүү үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг Хэрлэн суманд ашиглалтад оруулахаар ажиллаж байна.</p>	50
<p>төмрөөр баяжуулсан гурил үйлдвэрлээд байна.</p>	30
<p>Хэрлэн сумын "Ундрам" бүл хүүхдэд зориулан сүү, тараг 200 мл-р савлан үйлдвэрлэж ерөнхий боловсролын сургуулийн "Үдийн цай хөтөлбөр"-т нийлүүлж байна. "Хаш тун" хүүхдийн эмнэлэгт хүүхдийн хоол тэжээлийн үйлдвэрлэл эрхлэн сувилалын газрыг ажиллуулахаар төсөл ирүүлснийг дэмжин "ЖДҮ-ийг дэмжих сан"-гаас 20.0 сая төгрөгийн зээлийг олгоод байна. Одоогоор холбогдох тоног төхөөрөмжийг бэлтгэж, 50 гаруй метрийн гүний худгийг гаргаад байгаа бөгөөд байрны өргөтгөлийн ажлыг хийж гүйцэтгэж байна.</p>	30
<p>Аймгийн тариалангийн гол бүс нутгуудад байгаа атаршсан талбайг эргэлтэнд оруулах зорилгоор аймгийн 2009 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийт 16191 га атаршсан талбайг үр тариа тариалах зориулалтаар дуудлага худалдааны журмаар эзэмшүүлэхээр тусгуулсан. Мөн Биндэр сумын 2179 га атаршсан талбайг үр тариа тариалах зориулалтаар эзэмшүүлэхээр Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлтээр оруулсан.</p>	30

<p>Хэнтий аймгийн хурх тосгонд үйл ажиллагаа явуулдаг " Хурх гол" ХХКомпанийг түшиглэн үр үржүүлгийн аж ахуй байгуулах саналыг аймгийн Тариаланчдын зөвлөгөөнөөс манай аймгийн тариаланч ногоочдын төлөөлөл гаргасан бөгөөд одоогоор судалгааны шатандаа явагдаж байна. Мөн ХХААХҮЯамнаас 2010 онд үрийн аж ахуй байгуулах талаар тодорхой бодлого боловсруулж үйл ажиллагаа эхлүүлэхээр бэлтгэл ажил хийгдэж байна.</p>	10
<p>Хэнтий аймагт үр тарианы үйлдвэрлэл эрхлэдэг 17 аж ахуй нэгжүүд үйл ажиллагаагаа явуулж байдаг бөгөөд намрын хураан авсан ургацын ихэнхи хувийн Өмнөдэлгэр сумын Шар талын улсын үрийн нөөцөд тушааж борлуулж байна. Мөн тодорхой хэмжээний улаан буудайг гурил үйлдвэрлэдэг "Буудайн цацал" ХХК болон "Үүлэн хур ХХК-д нийлүүлж байна. үр тариа 6776га-д тариалж 10264тн буюу аймгийн дундажаар 14.0цн ургац хураан авсан</p>	50
<p>тариалж 4614 тн буюу нэгжээс 120.7 цн, хүнсний ногоо 180.1 га-д тариалж 2574 тн буюу 143 цн ургац тус тус хураан авсан. Төлөвлөгөөний биелэлт 99.2 хувь, Уриншийн боловсруулалтыг 10300 га-д боловсруулсан ба 2010 онд тариалалтын хэмжээг өмнөх оноос 2633га-аар нэмэгдүүлэн шаардагдах үрийн нөөцийг бүрдүүлэх зорилгоор орон нутгийн төсвөөс 100тн улаан буудайн үрийг нөөцөлү аваад байна. 2010 онд улаан буудай 10300га, төмс 382га, хүнсний ногоо198га, малын тэжээл 100га, жимс жимсгэнэ 5.5га-д тус тус тариалахаар бэлтгэл хангаад байна. Монгол Улсад Газар тариаланг бие даасан салбар болгон хөгжүүлсний 50 жилийн ойг угтаж зохиох 3 жилийн бүтээлч ажлын төлөвлөгөөг 2009 оны 4 дүгээр сарын 16 ны аймгийн тариаланчдын зөвлөгөөнөөр хэлэлцэж батлав. Мөн ойг угтаж Атар-50 уралдааны болзол гзарлаж Баян-Адарга сумын "Идэр-Онон" ХХК шалгарч атар газар эзэмшсэний 50 жилийн ойг 12 сард тэмдэглэн өнгөрүүллээ. Ойн арга хэмжээнд Засгийн газрын гишүүн, гадаад хэргийн Сайд Г.Занданшатарар ахлуулсан ажлын хэсэг болон аймаг орон нутгийн удирдлагууд, нийт 150 хүн оролцож төрийн дээд шагнал "Алтан гадас "одонгоор 2 тариаланч,</p>	50
<p>Нутгийн монгол хонь, ямааны ашиг шим, үүлдэрлэг байдлыг сайжруулах зорилгоор Барга омог, Үзэмчин үүлдрийн хээлтүүлэгч, Баяндэлгэрийн улаан ямаа, Галшарын улаан ухныг худалдан авчирч иргэд аж ахуй нэгжид сурталчилан борлуулах ажлыг зохион байгуулж байна. Өнгөрсөн жилүүдэд Барга омгийн хуц 23 толгой, Үзэмчин үүлдрийн хуц 123 толгойг малчид, мал бүхий иргэд худалдан зуучилж, үржилд ашигласнаар малын чанар сайжирч, шилмэл үүлдэр, омгийн мал сүрэг үржүүлэх сонирхол нь нэмэгдэж байна. Мах ноосны чиглэлийн нарийвтар ноост ТНЦ хонины тоо толгойг өсгөх, удмын санг хамгаалах зорилгоор өөр дотор нь цэврээр үржүүлэх, Орхон үүлдрийн хониор цус сэлбэх үржүүлгийн ажлыг Цөм сүргийн үржлийн төв гардан хийж байна.</p>	30

Монгол улсын Засгийн газрын 2006 оны 93-р тогтоол, ХХААСайдын 2008 оны 78-р тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор мал сүрэгт үзлэг ангилалт хийж, цөм сүрэг бий болгох тухай аймгийн Засаг даргын 2009 оны 05 сарын 22-ны өдрийн 133 тоот захирамжаар үзлэг ангиалалтыг хийсэн. Ангилалтанд 2539 хуц,1381 ухна,1640эм хонь, 696эм ямаа нийт 6256 толгой бог малыг хамруулж эзэмэгжүүлэн бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулсан. Малаа чанаржуулах хүсэлтэй, сум орон нутагтаа нэр хүндтэй, ажилч айл өрхийг сонгож цөм сүрэг бүхий загвар өрхийг сум болгонд бий болгох ажлыг эхлүүлээд байна. Уг ажлын хүрээнд Галшар, Баянхутаг, Дархан, Жаргалтхаан, Цэнхэрмандал, Мөрөн сумдад тус бүр 1 өрх, Баянмөнх, Дэлгэрхаан сумдад тус бүр 2 өрх, Өмнөдэлгэр суманд 3 загвар өрхийг бий болгож ХХААЖДҮГазар, сумын Засаг дарга, малчин өрхтэй гурвалсан гэрээг байгуулан ажилласнаар малчин өрхийн сүргийн чанарыг сайжруулах, хээлтүүлэгч малын биологийн чадавхийг бүрэн ашиглах, ашиг шимийн түвшинг дээшлүүлэх, сүргийн бүтцийг оновчтой бүрдүүлэх, нутгийн шилдэг омгийн мал болон цэвэр, эрлийз малын тоог нэмэгдүүлэх боломж бүрдэх юм.

30

Цөм сүргийн үржлийн төвд үржүүлэгдэж буй Тал нутгийн цагаан үүлдрийн хонины удмын санг хамгаалах, тоо толгойг олшруулах, үйл ажиллагааг тогтмолжуулах үүднээс ХХААХҮЯам, Улсын мал эмнэлэг,үржлийн газар, Малын удмын сангийн үндэсний төвтэй хамтран тоо толгой нь цөөрч байгаа мах-ноосны чиглэлийн Тал нутгийн цагаан үүлдрийн хонийг өсгөх, үржүүлж байсан Баянхутаг, Хэрлэн, Дадал сумдаас хонийг худалдан авч эрлийзжүүлгийн ажлыг зохион байгуулах, нарийн ноост цэвэр үүлдрийн хээлтүүлэгчээр сайжруулах, дээрх сумдад зохиомол хээлтүүлгийн суурин болон явуулын цэгийг байгуулан ажиллуулах зэргээр шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. ТНЦ үүлдрийн хонийг өсгөн үржүүлсний ач холбогдлыг малчид, мал бүхий иргэдэд сурталчлан таниулах, нарийн нарийвтар ноосоор бүтээгдэхүүн үйлдвэрлэх, “ Тал нутгийн цагаан “ үүлдрийн хонины арьс, ноосоор хийсэн бүтээгдэхүүнийг аймгийн брэнд бүтээгдэхүүн болгох, түүний нэр төрлийг олшруулах, дэмжих зорилгоор 2009 оны 07 сарын 11-12-ны өдрүүдэд “ Гар урлалын уралдаан “-ыг зохион байгуулан ажиллаж байна.

30

ХХААХҮйлдвэрийн сайдын тушаалаар "Биржийн тухай" хууль боловсруулагдах ажлын хэсэг томилогдон ажиллаж байгаатай холбоотойгоор сүүлийн 4 жил түүхий эд бэлтгэлээр тогтвортой ажиллаж байгаа, худалдан авалт хийж байгаа, цаашид тогтвортой ажиллах хүсэлтэй бизнес эрхлэгчдийн судалгааг түүхий эд бэлтгэгч бүртэй биечлэн уулзаж гаргасан.

10

<p>Малын гаралтай түүхий эд бэлтгэлийн анхан шатны хоршоо, нөхөрлөлүүдийг байгуулахаар нөхөрлөл болон ажиллах хүсэлтэй иргэдийн дунд төсөл сонгон шалгаруулалт зарласан бөгөөд уг төсөлд шалгарсан нөхөрлөл, иргэдэд дэмжлэг үзүүлэн төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 2009 онд Дэлгэрхаан суманд УИХ-ын гишүүн Б.Бат-эрдэнэ малын гаралтай түүхий эдийг худалдан авах зах зээлд борлуулах зорилготой хөдөө аж ахуйн биржийг байгуулахаар ажиллаж хөнгөлөлттэй зээл олгоод байна.</p>	30
<p>Монгол улсын Засгийн газрын 2007 оны 283 дугаар тогтоолоор батлагдсан “Малын тэжээл” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2008 оны 48-р тогтоолоор “Малын тэжээл” аймгийн дэд хөтөлбөр, салбар зөвлөл байгуулан ажиллаж байна. Хэнтий аймаг дахь улсын нөөцийн салбар болох Хэрлэнбаян-Улаан, Бэрх тосгонд аж ахуйн нэгжүүд гэрээ байгуулан нөөцийн өвс бэлтгэдэг ба аймгийн хойд талын сумдууд</p>	10
<p>Аймаг болон сум дундын отрын бүс нутаг болох Хэрлэнбаян-Улааны бэлчээрийн нөхөн сэргээлт, ургамал хамгаалалын арга хэмжээг холбогдох газруудтай хамтран зохион байгуулсан ба тус бүс нутгийн бэлчээрийн даац 3-4 дахин хэтэрч уг нутгийг 2 жил чөлөөлөх шийдвэрийг Засгийн газраас гаргаад байна. Дэлгэрхаан сумын отрын бүс нутагт байгаа нүүх шаардлагатай айл өрхийн судалгааг сум, багаар дэлгэрэнгүй гаргалаа. Аймаг дундын отрын бүс Хэрлэнбаян-Улаан тосгоны нутагт тус аймгийн Дэлгэрхаан, Жаргалтхаан, Цэнхэрмандал сумдын 272 өрхөд эзэмшлийн гэрчилгээ бүхий өвөлжөө, хаваржааны хашаа 190, саравч 162, хороо 10 байна. Уг бүс нутагт байсан Жаргалтхаан, Цэнхэрмандал, Дэлгэрхаан сумдын малыг нүүлгэн шилжүүлж, тус бүс нутагт улсын төсвийн хөрөнгөөр 2худаг шинээр гаргахаар болсон. Мөн 200га газарт усалгаатай хадлангийн талбайг хашиж хамгаалах ажил хийгдэж байна.</p>	30
<p>халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх арга хэмжээний талаар төрөлжсөн семинар сургалтуудыг зохион байгуулсан. Мөн малын эмч</p>	30
<p>Орон нутагт мал эмнэлгийн ажил үйлчилгээ эрхлэн явуулж байгаа аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагааг бэхжүүлэх зорилгоор ХХААХҮЯамнаас боловсруулсан уг хөтөлбөрт оруулах саналуудыг мал эмнэлгийн үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа аж ахуйн нэгжүүдээс авч нэгтгэн хүргүүлсэн.</p>	10

<p>2009 онд улсын төвсийн хөрөнгө оруулалтаар бэлчээр усжуулах арга хэмжээнд зориулж 80 сая төгрөгөөр 5 суманд 6 худаг, ХЯБХ-ийн хөрөнгөөр 5 худаг, малчид өөрсдийн хүчээр 3 худгийг гаргаж, ХБУ-ын отрын бүс нутагт 2 худаг нийт 16 худаг гаргаж 45,5 мянган га бэлчээрийг усжуулсан байна. Малчид иргэдийн оролцоотойгоор нийт 38 энгийн уурхайн худаг гаргаж 76,0 мянган га бэлчээрийг нэмж усжуулсан байна.</p>	50
<p>Газрын доорхи усны геофизикийн хайгуул хийгдэх ажил эхлээгүй байна. 2010 онд ХХААХҮСайдтай аймгийн Засаг даргын бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд 80 уст цэгт хайгуулын ажил хийгдэхээр тусгагдсан бөгөөд 80 уст цэгийн дэлгэрэнгүй судалгааг ХХААХҮЯаманд хүргүүлсэн.</p>	10
<p>Атрын гурав дахь аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгийн тариалангийн гол бүс нутгуудад байгаа атаршсан талбайг эргэлтэнд оруулах зорилгоор аймгийн 2009 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийт 16191 га атаршсан талбайг үр тариа тариалах зориулалтаар дуудлага худалдааны журмаар эзэмшүүлэхээр тусгуулсан. Мөн Биндэр сумын 2179 га атаршсан талбайг үр тариа тариалах зориулалтаар эзэмшүүлэхээр Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлтээр оруулсан.</p> <p>Эдгээр төлөвлөгөөнд тусгуулсан газруудаас эхний хагас жилд Хэрлэн сумын Өлзийт тосгонд атаршсан 10000 га тариалангийн талбайг иргэн Баярцэцэгт, Биндэр суманд 2179га талбайг “Биндэръяа Буудай” ХХК-д нийт 12179 га атаршсан тариалангийн талбай дуудлага худалдаагаар эзэмшүүлж орон нутгийн төсөвт 59869700 төгрөгийг төвлөрүүлээд байна. Энэ онд аймгийн үр тарианы үйлдвэрлэл эрхлэдэг аж ахуйн нэгж, иргэд 15000 га-д хүргэж уриншийн боловсруулалт хийж дараа оны тариалалтандаа бэлтгэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.</p>	50

<p>Эрдэс баялаг эрчим хүчний яаманд манай аймгийн нутаг дэвсгэр дээрхи цахилгааны эрчим хүчний шугам сүлжээнд холбогдох боломжтой цахилгааны трассад ойр орших багийн төв, хот айл, суурингийн талаархи судалгааг гарган хүргүүлсэн. Энэ судалгааны хүрээнд Эрдэс баялаг эрчим хүчний яам, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Хэрлэн сумын 8-р баг Тахилгат тосгоныг төвлөрсөн эрчим хүчинд холбохоор болсон. Хэрлэн сумаас зүүн тийш ногоочидруу тавигдсан 3 км 0.6 кВ-тын шугамаас залгуулан 2,5 км цахилгаан дамжуулах агаарын шугамыг барьж дуусган нийтдээ орон нутгийн хөрөнгө оруулалт 72 сая төгрөгөөр хийж гүйцэтгэлээ. Мөн Хэрлэн сумын 2, 3, 5, 6 дугаар багт шинээр газар олголт ихээр хийгдэж байгаатай холбоотой 6, 0.4 кв-ын дэд станц, цахилгаан дамжуулах агаарын шугам барих шаардлагатай болж байгаа бөгөөд Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсаны дагуу 2010 оноос уг ажлыг хэрэгжүүлж иргэдийг цахилгаан эрчим хүчээр хангахаар ажиллаж байна.</p>	50
<p>“Хэнтий намрын баяр -2009” өдөрлөгийг 2009 оны 9 дүгээр сард Өндөрхаан хотноо зохион байгуулж "Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" шилдэг бүтээгдэхүүнийг 9 нэр төрлөөр шалгарууллаа. Өдөрлөгийн арга хэмжээнд нийт 16 сум, 3 тосгоны 300-гаад үйлдвэрлэгч, бизнес эрхлэгч, ногоочид оролцож 35 нэр төрлийн 79,0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. “Хэнтий намрын баяр -2009” өдөрлөгт амжилттай оролцсон үйлдвэрлэгчдийг мөн Дэлхийн байгаль хамгаалах сангийн “Онон балжийн сав газрыг хамгаалах” төсөлтэй хамтран Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Баян-адрага, Дадал, Баян-Овоо, Цэнхэрмандал зэрэг 7 сумын 20 аж ахуйн нэгж, иргэнийг хамруулж Улаанбаатар хотод зохион байгуулагдсан "Намрын баяр 2009" үзэсгэлэнд амжилттай оролцсон.</p>	100

<p>2009 онд ЕБС-ийн үдийн цай хөтөлбөрт хамрагддаг сурагчид болон цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд “Хүүхэд бүрт аяга сүү аян”-ыг амжилттай зохион байгуулж 14 сумын 5314 сурагчид хамрагдан 7074 л сүүг малчдаас шууд нийлүүлэн мал эмнэлгийн шинжилгээнд хамруулан сурагчдад өгсөн. Батширээт суманд "Сүү" ХК-ний салбар хоногт 10 тн сүү боловсруулах цех, Биндэр суманд хоногт 1 тн сүү боловсруулах цехийг ашиглалтанд оруулан үйл ажиллагаагаа явуулж байна. Дадал, Хэрлэн сумдад Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Сүү” төслийн хүрээнд 5.9 сая төгрөгийн өртөгтэй 1 жилийн дараагаас эхлэн 2 жилийн хугацаанд хүүгүй, эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах тоног төхөөрөмжийг суурилуулан үйл ажиллагаагаа явуулж байна. Улсын төсвийн төвлөрсөн хөрөнгө оруулалтаар Өндөрхаан хотод баригдаж буй хоногт 2 тн сүү боловсруулах хүчин чадалтай сүүний үйлдвэр нь барилгын засвар тохижилтын ажил дуусч, тоног төхөөрөмжийн угсралт хийгдэж байна. Хэрлэн суманд "Мах экспорт" ХХК-ний салбар хоногт 120 бод, 250-300 бог нядлаж боловсруулах хүчин чадалтай махны анхан шатны боловсруулалт хийх үйлдвэрийн барилга болон тоног төхөөрөмжийн угсралтын ажил дуусч, үйл ажиллагаа нь 2009 оны 8-р сараас эхэлсэн. Тус үйлдвэр экспортод нийлүүлэх 250 гаруй тн мах боловсруулаад байна. Энэхүү үйлдвэр нь 52 ажлын байрыг бий болгоод байна.</p>	30
<p>Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх дэд сангаас Чацаргана тарих зориулалтаар Хэрлэн, Дадал, Баян-Адрага сумдын 3 иргэнд нийт 18.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Мөн "Мах экспорт" ХХК нь Хэрлэн голын эрэг дээр 100га талбайд чацаргана тариалахаар ХХААХҮЯаманд зарлагдсан услалтын системийн тендерт оролцож ялсан бөгөөд үйл ажиллагаагаа явуулахаар бэлтгэл ажил хийгдэж байна.</p>	30
<p>үнсний аюулгүй байдлын бодлого</p>	
<p>Батширээт суманд "Сүү" ХК-ний салбар хоногт 10 тн сүү боловсруулах цех, Биндэр суманд хоногт 1 тн сүү боловсруулах цехийг ашиглалтанд оруулан үйл ажиллагаагаа явуулж байна. Дадал, Хэрлэн сумдад Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Сүү” төслийн хүрээнд 5.9 сая төгрөгийн өртөгтэй 1 жилийн дараагаас эхлэн 2 жилийн хугацаанд хүүгүй, эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах тоног төхөөрөмжийг суурилуулан үйл ажиллагаагаа явуулж байна. Улсын төсвийн төвлөрсөн хөрөнгө оруулалтаар Өндөрхаан хотод баригдаж буй хоногт 2 тн сүү боловсруулах хүчин чадалтай сүүний үйлдвэр нь барилгын засвар тохижилтын ажил дуусч, тоног төхөөрөмжийн угсралт хийгдэж байна.</p>	30

Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа 4 аж ахуйн нэгж Хэнтий аймгийн хэмжээнд ажиллаж байна. Хэрлэн сумын төвд ажиллаж байгаа 2 аж ахуйн нэгж нь боловсруулсан сүү, тараг үйлдвэрлэн савлаж борлуулж байгаа ба Батширээт суманд 2009 оны 7 сард байгуулагдсан сүү боловсруулах цех нь мал бүхий иргэдээс хоногт 3,0 тн сүү худалдан авч, стандартын шаардлага хангасан цөцгийн тос, аарц үйлдвэрлэж, Сүү ХК-д нийлүүлж байна. Малчид, фермерүүдийн сүүг нэгдсэн байдлаар цуглуулан хөргөж, боловсруулан хоногт 2 тн сүү үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг Хэрлэн суманд ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

50

Буудайн цацал ХХК нь гурилыг төмрөөр баяжуулах тоног төхөөрөмж суурьлуулсан бөгөөд энэ жилийн хураасан ургацын улаан буудайгаар 150 тн төмрөөр баяжуулсан гурил үйлдвэрлээд байна.

30

Тус хөтөлбөрт 36 аж ахуй нэгж, 3023 өрх хамрагдаж төмс 382.8 га-д, хүнсний ногоо 180 га-д тариалж төмс 4614.4 тн, хүнсний ногоо 2574 тн-ийг тус тус хураан авсан. Аймгийн хэмжээгээр 1662 тн багтаамж бүхий 66 зоорь ашиглаж 352 тн төмс үрэнд нөөцлөж, даршилж боловсруулсан ногоо, жимс 102621шил, энгийн худаг 147, гүний худаг 27 ашиглаж нийт 178.4 сая төгрөгийг энэ хөтөлбөрийн үйл ажиллагаанд зарцуулсан байна. Үүнээс орон нутгийн төсвөөс 16.0 сая, бусад эх үүсвэрээс 3.2 сая, хуримтлалаас 2.2 сая төгрөг зарцуулжээ. Хөтөлбөр хэрэгжих хугацаанд 50 удаагийн сургалтаар 2751 хүн хамруулж 2610 ширхэг зөвлөмж тарааж өгсөн. Агропарк төслийн хүрээнд 17 суманд агропарк байгуулагдаж үйл ажиллагаа явуулж байгаа ба сум бүрээс 2 ногоочдын төлөөлөгч оролцуулан хаврын тариалалтын ажлаас өмнө төмс хүнсний ногооны технологийн сургалтыг 2 өдөр зохион байгуулав. Мөн агропаркуудад 5 төрлийн 563.0 мянган төгрөгийн хүнсний ногооны үрийн дэмжлэг үзүүлж ажиллав. Аймгийн нөөц сангаас агропаркууд болон ногоочдод 20 тн буюу 16.0 сая төгрөгийн үнэ бүхий Голландын Санта сортын төмсний үрийг нийлүүлснээр аймгийн хэмжээнд үрийн төмсний хүрэлцээ хангамжийн дийлэнхийг цэвэр сортын үрээр нэмэгдүүлж ард иргэдийг эх орны эрүүл хүнсээр хангаж байна.

50

<p>Хэрлэн сумын "Ундрэм" бүл хүүхдэд зориулан сүү, тараг 200 мл-р савлан үйлдвэрлэж ерөнхий боловсролын сургуулийн "Үдийн цай хөтөлбөр"-т нийлүүлж байна. "Хаш тун" хүүхдийн эмнэлэгт хүүхдийн хоол тэжээлийн үйлдвэрлэл эрхлэн сувилалын газрыг ажиллуулахаар төсөл ирүүлснийг дэмжин "ЖДҮ-ийг дэмжих сан"-гаас 20.0 сая төгрөгийн зээлийг олгоод байна. Одоогоор холбогдох тоног төхөөрөмжийг бэлтгэж, 50 гаруй метрийн гүний худгийг гаргаад байгаа бөгөөд байрны өргөтгөлийн ажлыг хийж гүйцэтгэж байна.</p>	30
<p>Аймгийн тариалангийн гол бүс нутгуудад байгаа атаршсан талбайг эргэлтэнд оруулах зорилгоор аймгийн 2009 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийт 16191 га атаршсан талбайг үр тариа тариалах зориулалтаар дуудлага худалдааны журмаар эзэмшүүлэхээр тусгуулсан. Мөн Биндэр сумын 2179 га атаршсан талбайг үр тариа тариалах зориулалтаар эзэмшүүлэхээр Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлтээр оруулсан.</p>	30
<p>Хэнтий аймгийн хурх тосгонд үйл ажиллагаа явуулдаг " Хурх гол" ХХКомпанийг түшиглэн үр үржүүлгийн аж ахуй байгуулах саналыг аймгийн Тариаланчдын зөвлөгөөнөөс манай аймгийн тариаланч ногоочдын төлөөлөл гаргасан бөгөөд одоогоор судалгааны шатандаа явагдаж байна. Мөн ХХААХҮЯамнаас 2010 онд үрийн аж ахуй байгуулах талаар тодорхой бодлого боловсруулж үйл ажиллагаа эхлүүлэхээр бэлтгэл ажил хийгдэж байна.</p>	10
<p>Хэнтий аймагт үр тарианы үйлдвэрлэл эрхлэдэг 17 аж ахуй нэгжүүд үйл ажиллагаагаа явуулж байдаг бөгөөд намрын хураан авсан ургацын ихэнхи хувийн Өмнөдэлгэр сумын Шар талын улсын үрийн нөөцөд тушааж борлуулж байна. Мөн тодорхой хэмжээний улаан буудайг гурил үйлдвэрлэдэг "Буудайн цацал" ХХК болон "Үүлэн хур ХХК-д нийлүүлж байна. үр тариа 6776га-д тариалж 10264тн буюу аймгийн дундажаар 14.0цн ургац хураан авсан</p>	50

<p>Нутгийн монгол хонь, ямааны ашиг шим, үүлдэрлэг байдлыг сайжруулах зорилгоор Барга омог, Үзэмчин үүлдрийн хээлтүүлэгч, Баяндэлгэрийн улаан ямаа, Галшарын улаан ухныг худалдан авчирч иргэд аж ахуй нэгжид сурталчилан борлуулах ажлыг зохион байгуулж байна. Өнгөрсөн жилүүдэд Барга омгийн хуц 23 толгой, Үзэмчин үүлдрийн хуц 123 толгойг малчид, мал бүхий иргэд худалдан зуучилж, үржилд ашигласнаар малын чанар сайжирч, шилмэл үүлдэр, омгийн мал сүрэг үржүүлэх сонирхол нь нэмэгдэж байна. Мах ноосны чиглэлийн нарийвтар ноост ТНЦ хонины тоо толгойг өсгөх, удмын санг хамгаалах зорилгоор өөр дотор нь цэврээр үржүүлэх, Орхон үүлдрийн хониор цус сэлбэх үржүүлгийн ажлыг Цөм сүргийн үржлийн төв гардан хийж байна.</p>	<p>30</p>
<p>Монгол улсын Засгийн газрын 2006 оны 93-р тогтоол, ХХААСайдын 2008 оны 78-р тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор мал сүрэгт үзлэг ангилалт хийж, цөм сүрэг бий болгох тухай аймгийн Засаг даргын 2009 оны 05 сарын 22-ны өдрийн 133 тоот захирамжаар үзлэг ангилалтыг хийсэн. Ангилалтанд 2539 хуц,1381 ухна,1640эм хонь, 696эм ямаа нийт 6256 толгой бог малыг хамруулж ээмэгжүүлэн бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулсан. Малаа чанаржуулах хүсэлтэй, сум орон нутагтаа нэр хүндтэй, ажилч айл өрхийг сонгож цөм сүрэг бүхий загвар өрхийг сум болгонд бий болгох ажлыг эхлүүлээд байна. Уг ажлын хүрээнд Галшар, Баянхутаг, Дархан, Жаргалтхаан, Цэнхэрмандал, Мөрөн сумдад тус бүр 1 өрх, Баянмөнх, Дэлгэрхаан сумдад тус бүр 2 өрх, Өмнөдэлгэр суманд 3 загвар өрхийг бий болгож ХХААЖДҮГазар, сумын Засаг дарга, малчин өрхтэй гурвалсан гэрээг байгуулан ажилласнаар малчин өрхийн сүргийн чанарыг сайжруулах, хээлтүүлэгч малын биологийн чадавхийг бүрэн ашиглах, ашиг шимийн түвшинг дээшлүүлэх, сүргийн бүтцийг оновчтой бүрдүүлэх, нутгийн шилдэг омгийн мал болон цэвэр, эрлийз малын тоог нэмэгдүүлэх боломж бүрдэх юм.</p>	<p>30</p>

<p>Цөм сүргийн үржлийн төвд үржүүлэгдэж буй Тал нутгийн цагаан үүлдрийн хонины удмын санг хамгаалах, тоо толгойг олшруулах, үйл ажиллагааг тогтмолжуулах үүднээс ХХААХҮЯам, Улсын мал эмнэлэг, үржлийн газар, Малын удмын сангийн үндэсний төвтэй хамтран тоо толгой нь цөөрч байгаа мах-ноосны чиглэлийн Тал нутгийн цагаан үүлдрийн хонийг өсгөх, үржүүлж байсан Баянхутаг, Хэрлэн, Дадал сумдаас хонийг худалдан авч эрлийзжүүлгийн ажлыг зохион байгуулах, нарийн ноост цэвэр үүлдрийн хээлтүүлэгчээр сайжруулах, дээрх сумдад зохиомол хээлтүүлгийн суурин болон явуулын цэгийг байгуулан ажиллуулах зэргээр шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. ТНЦ үүлдрийн хонийг өсгөн үржүүлсний ач холбогдлыг малчид, мал бүхий иргэдэд сурталчлан таниулах, нарийн нарийвтар ноосоор бүтээгдэхүүн үйлдвэрлэх, " Тал нутгийн цагаан " үүлдрийн хонины арьс, ноосоор хийсэн бүтээгдэхүүнийг аймгийн брэнд бүтээгдэхүүн болгох, түүний нэр төрлийг олшруулах, дэмжих зорилгоор 2009 оны 07 сарын 11-12-ны өдрүүдэд " Гар урлалын уралдаан "-ыг зохион байгуулан ажиллаж байна.</p>	30
<p>Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Баян –Адарга сумын Дуурлигт саалийн үхрийн, Улаан жирээд үхрийн бордооны аж ахуй, Дадал сумын Цээнтэд зөгийн аж ахуй, Галтгайд сүүний үхрийн аж ахуй, Хэрлэн суманд сүүний үхрийн аж ахуй 2, шувууны аж ахуйн, гахайн аж ахуй, мах-ноосны чиглэлийн хонины аж ахуй, Мөрөн суманд Эхэн усанд сүүний үхрийн эрчимжсэн аж ахуй эрхлэхээр газар нутгийг сонгосон. Хэрлэн сумын 8-р багийн Тахилгат тосгоны нутаг дэвсгэрт Цөм сүргийн үржлийн төвд үржүүлэгдэж буй мах ноосны чиглэлийн Тал нутгийн цагаан үүлдрийн хонь цэврээр үржүүлэгдэж байгаа бөгөөд уг хонины удмын сан генофондыг хамгаалах ажил явагдаж байна.</p>	30
<p>Сүү махны арвин ашиг шимт малын тоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд малын тоо толгойг нэмэгдүүлэх, малын чанарыг сайжруулах, өндөр ашиг шимтэй цэвэр, эрлийз малын гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийх зэрэг ажлуудыг шат дараалан авч хэрэгжүүлж байна. Мэргэжилтэй техникч бэлтгэх сургалтанд жил бүр сумдаас хүмүүсийг хамруулж байна.</p>	50

<p>Өмнөдэлгэр сумын "Хурх гол" ХХКомпани нь эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд махны чиглэлийн үхрийн аж ахуй, Хурх тосгонд үйл ажиллагаа явуулж байгаа "Буудайн цацал" ХХКомпани нь махны чиглэлийн хонины аж ахуй, Цэнхэрмандал сумын Нугаар багийн иргэн О.Батсүх ашиг шим өндөртэй үхрийн загвар фермерийн аж ахуй эрхлэн үйл ажиллагаа явуулж байна. Шинээр эрчимжсэн болон хагас эрчимжсэн фермерийн аж ахуйг эрхлэх сонирхолтой иргэд аж ахуйг дэмжиж сүүний үхрийн -25, махны чиглэлийн үхрийн -4, хонины-2, тахиа гахайны -7 төсөл ирж санхүүжилт аваад байгаа сүүний үхрийн- 3 иргэн 35 сая төгрөгийн, 6- аж ахуйн нэгж 121 сая төгрөг, махны чиглэлийн үхэр өсгөхөөр 2 иргэнд 13 сая төгрөг, шувууны аж ахуй эрхлэхээр- 2 иргэнд 30 сая төгрөг тус тус олгоод байна.</p>	50
<p>ХХААХҮйлдвэрийн сайдын тушаалаар "Биржийн тухай" хууль боловсруулагдах ажлын хэсэг томилогдон ажиллаж байгаатай холбоотойгоор сүүлийн 4 жил түүхий эд бэлтгэлээр тогтвортой ажиллаж байгаа, худалдан авалт хийж байгаа, цаашид тогтвортой ажиллах хүсэлтэй бизнес эрхлэгчдийн судалгааг түүхий эд бэлтгэгч бүртэй биечлэн уулзаж гаргасан.</p>	10
<p>Малын гаралтай түүхий эд бэлтгэлийн анхан шатны хоршоо, нөхөрлөлүүдийг байгуулахаар нөхөрлөл болон ажиллах хүсэлтэй иргэдийн дунд төсөл сонгон шалгаруулалт зарласан бөгөөд уг төсөлд шалгарсан нөхөрлөл, иргэдэд дэмжлэг үзүүлэн төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 2009 онд Дэлгэрхаан суманд УИХ-ын гишүүн Б.Бат-эрдэнэ малын гаралтай түүхий эдийг худалдан авах зах зээлд борлуулах зорилготой хөдөө аж ахуйн биржийг байгуулахаар ажиллаж хөнгөлөлттэй зээл олгоод байна.</p>	30
<p>Монгол улсын Засгийн газрын 2007 оны 283 дугаар тогтоолоор батлагдсан "Малын тэжээл" хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2008 оны 48-р тогтоолоор "Малын тэжээл" аймгийн дэд хөтөлбөр, салбар зөвлөл байгуулан ажиллаж байна. Хэнтий аймаг дахь улсын нөөцийн салбар болох Хэрлэнбаян-Улаан, Бэрх тосгонд аж ахуйн нэгжүүд гэрээ байгуулан нөөцийн өвс бэлтгэдэг ба аймгийн хойд талын сумдууд төлөвлөгөөт хадлангаас гадна сумын хэмжээнд өвс тэжээлийн аюулгүй фонд байгуулж ажиллаж байна. 2009 онд Хэрлэн сумын нутаг дэвсгэрт хойд талын сумдаас байгалийн хадлан бэлтгэн урд талын сумдын өвс тэжээлийн хэрэгцээг хангах тэжээлийн фонд байгуулах ажил эхлэлийн шатанд явагдаж байна.</p>	10

<p>Аймгийн хэмжээнд сүүлийн 3 жилд хадлан тэжээл бэлтгэх бага оврын трактортой болсон малчин өрх -151, аж ахуйн нэгж 3 байна. 2009 онд аймгийн хэмжээнд ашиглаж байгаа хадлангийн техник хэрэгслийн судалгаагаар том оврын трактор-41, дүүжин хадуур-36, тармуур -53, хаман боогч-6, бага оврын трактор 285 –ийг ашиглаж байна. Аймгийн хэмжээнд бага оврын трактор-156, хаман боогч-9, хадуур -3, тармуур-2 нэмж шаардагдах судалгаа байна. 2009 онд 92.1 тн байгалийн хадлан, 104 тн гар тэжээл, 3000ширхэг багсармал тэжээлийг бэлтгэсэн. Мөн үр тарианы үйлдвэрлэл эрхлэж байгаа аж ахуйн нэгжүүдэд хадгалагдаж байсан хаягдал будаагаар 530-аад тн багсармал тэжээлийг орон нутгийн нөөц бололцоогоор үйлдвэрлэн малчдад 7 дугаарс арын 1-ыг хүртэл зээлээр олгох ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p>	<p>30</p>
<p>Аймаг болон сум дундын отрын бүс нутаг болох Хэрлэнбаян-Улааны бэлчээрийн нөхөн сэргээлт, ургамал хамгаалалын арга хэмжээг холбогдох газруудтай хамтран зохион байгуулсан ба тус бүс нутгийн бэлчээрийн даац 3-4 дахин хэтэрч уг нутгийг 2 жил чөлөөлөх шийдвэрийг Засгийн газраас гаргаад байна. Дэлгэрхаан сумын отрын бүс нутагт байгаа нүүх шаардлагатай айл өрхийн судалгааг сум, багаар дэлгэрэнгүй гаргалаа. Аймаг дундын отрын бүс Хэрлэнбаян-Улаан тосгоны нутагт тус аймгийн Дэлгэрхаан, Жаргалтхаан, Цэнхэрмандал сумдын 272 өрхөд эзэмшлийн гэрчилгээ бүхий өвөлжөө, хаваржааны хашаа 190, саравч 162, хороо 10 байна. Уг бүс нутагт байсан Жаргалтхаан, Цэнхэрмандал, Дэлгэрхаан сумдын малыг нүүлгэн шилжүүлж, тус бүс нутагт улсын төсвийн хөрөнгөөр 2худаг шинээр гаргахаар болсон. Мөн 200га газарт усалгаатай хадлангийн талбайг хашиж хамгаалах ажил хийгдэж байна.</p>	<p>30</p>

<p>Аймгийн мал аж ахуйн мэргэжилтний зөвлөгөөнийг 2009.03.18 нд зохион байгуулж зөвлөгөөнд оролцогчдод зориулан Малын гоц халдварт болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх арга хэмжээний талаар төрөлжсөн семинар сургалтуудыг зохион байгуулсан. Мөн малын эмч мэргэжилтнүүдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор УМЭАЦТЛаборатороос зохион байгуулсан “ шувууны томуугаас урьдчилан сэргийлэх болон авах арга хэмжээ” сэдэвт сургалт, “ Малын халдваргүй өвчний тулгамдсан асуудал эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн бага хурал”, “ Эндемик өвчний талаархи сургалтуудад эмч нараа бүрэн хамруулсан нь үр дүнгээ өгсөн болно.</p>	<p>30</p>
<p>Орон нутагт мал эмнэлгийн ажил үйлчилгээ эрхлэн явуулж байгаа аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагааг бэхжүүлэх зорилгоор ХХААХҮЯамнаас боловсруулсан уг хөтөлбөрт оруулах саналуудыг мал эмнэлгийн үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа аж ахуйн нэгжүүдээс авч нэгтгэн хүргүүлсэн.</p>	<p>10</p>
<p>2009 онд улсын төвсийн хөрөнгө оруулалтаар бэлчээр усжуулах арга хэмжээнд зориулж 80 сая төгрөгөөр 5 суманд 6 худаг, ХЯБХ-ийн хөрөнгөөр 5 худаг, малчид өөрсдийн хүчээр 3 худгийг гаргаж, ХБУ-ын отрын бүс нутагт 2 худаг нийт 16 худаг гаргаж 45,5 мянган га бэлчээрийг усжуулсан байна. Малчид иргэдийн оролцоотойгоор нийт 38 энгийн уурхайн худаг гаргаж 76,0 мянган га бэлчээрийг нэмж усжуулсан байна.</p>	<p>50</p>
<p>Газрын доорхи усны геофизикийн хайгуул хийгдэх ажил эхлээгүй байна. 2010 онд ХХААХҮСайдтай аймгийн Засаг даргын бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд 80 уст цэгт хайгуулын ажил хийгдэхээр тусгагдсан бөгөөд 80 уст цэгийн дэлгэрэнгүй судалгааг ХХААХҮЯаманд хүргүүлсэн.</p>	<p>10</p>

<p>Сумдаас үлийн цагаан оготно тархсан бэлчээр нутгийн судалгааг авч, улсын хөрөнгө оруулалтаар устгал хийлгэх талаар ХААХҮЯаманд санал тавьсны дагуу Ургамал хамгаалал, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн ажилтнууд тандалтын судалгаа хийсэн. Тандалтын судалгаагаар Галшар суманд 4.0 мянга, Дархан суманд 5.0 мянга, Дэлгэрхаан суманд 8.0 мянга, Баянмөнх суманд 5.0 мянга, Батноров суманд 3.0 мянга, Хэрлэн суманд 5.0 мянга нийт 30 мянган га бэлчээрт "Механик, биологийн арга"-аар тэмцэх ажиллагааг Ургамал эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран зохион байгуулах бөгөөд суманд Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг газар дээр нь гардан зохион байгуулан ажиллаа. Мөн биологийн аргаар мэрэгч амьтантай тэмцэх зорилгоор Дархан, Баянмөнх, Баянхутаг, Галшар сумдад идлэг шонхор шувууны 1000 ширхэг хиймэл үүрийг 6 дугаар сараас эхлэн байршууллаа.</p>	30
<p>Аймгийн хэмжээнд Хөдөө аж ахуйн, Үйлдвэрлэгчдийн, Үйлдвэр үйлчилгээний, Худалдаа эд эрхлэгчдийн гэсэн 4 холбоо 14 суманд ажиллаж нийт 54 хоршоо үйл ажиллагаа явуулж байна. 2009 онд Батширээт сумын "Батширээт цөцгий" хоршоо байгуулагдан, Хэнтий аймгийн хоршоог дэмжих төрийн бус байгууллага байгуулах ажил хийгдээд байна. 2009 оныг "Үйлдвэржүүлэлтийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан 14 хоршоонд үйлдвэрийн чиглэлд оруулахаар саналыг бүртгүүлэн төсөл бичих зөвлөгөө өгсөнөөс Явын булаг хоршоо, Нугаар хайрхан хоршоод төслийн зээлэнд хамрагдаад байна. 2009 оны 6-р сарын 10-ны өдрийн 173 дугаар тогтоолоор "Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр 2" багтлагдан гарсан бөгөөд уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж байна. Хөтөлбөрийг 2009-2013 он, 2013-2017 он гэсэн 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.</p>	30
<p>Зооноз өвчний голомтой сумдуудад голомтын ариутгал хийж, бруцелёз өвчнөөс эрүүлжүүлэх хөтөлбөрийг боловсруулж Засгийн газрын хэрэгжүүлэх агентлаг Улсын мал эмнэлэг, үржлийн газарт хургүүлээд байна.</p>	30

<p>Атрын гурав дахь аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгийн тариалангийн гол бүс нутгуудад байгаа атаршсан талбайг эргэлтэнд оруулах зорилгоор аймгийн 2009 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийт 16191 га атаршсан талбайг үр тариа тариалах зориулалтаар дуудлага худалдааны журмаар эзэмшүүлэхээр тусгуулсан. Мөн Биндэр сумын 2179 га атаршсан талбайг үр тариа тариалах зориулалтаар эзэмшүүлэхээр Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлтээр оруулсан.</p> <p>Эдгээр төлөвлөгөөнд тусгуулсан газруудаас эхний хагас жилд Хэрлэн сумын Өлзийт тосгонд атаршсан 10000 га тариалангийн талбайг иргэн Баярцэцэгт, Биндэр суманд 2179га талбайг “Биндэръяа Буудай” ХХК-д нийт 12179 га атаршсан тариалангийн талбай дуудлага худалдаагаар эзэмшүүлж орон нутгийн төсөвт 59869700 төгрөгийг төвлөрүүлээд байна. Энэ онд аймгийн үр тарианы үйлдвэрлэл эрхлэдэг аж ахуйн нэгж, иргэд 15000 га-д хүргэж уриншийн боловсруулалт хийж дараа оны тариалалтандаа бэлтгэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.</p>	50
<p>2009 онд 10300 га д уриншийн боловсруулалтыг хийж бэлтгээд байна.</p>	50
<p>Өндөрхаан хотод төмс, хүнсний ногоо борлуулах бөөний цэг байгуулахаар аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусган ажиллаж байна. Хэрлэн сумын Хурх хүнсний захын хойд талд байрлах бөөний цэг нь өөрийн байрыг засварлан өргөтгөж шинэчилэн иргэдэд тав тухтай орчинд худалдаа хийх боломжийг бүрдүүлж өгсөн. Мөн 3-р багийн нутаг дэвсгэрт Мөрөн сумын ногоочин Л.Нямаа нь төмс, хүнсний ногоо борлуулах бөөний цэгийг шинээр байгуулан ажиллаж байна. 2009 онд Дэлгэрхаан суманд УИХ-ын гишүүн Б.Бат-эрдэнэ малын гаралтай түүхий эдийг худалдан авах зах зээлд борлуулах зорилготой хөдөө аж ахуйн биржийг байгуулахаар ажиллаж байна</p>	30

, хот байгуулалтын бодлого	
<p>Монгол Улсын иргэн бүрт газар өмчлүүлэх талаар хуулинд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдож 2008-2012 онд газар өмчлүүлэх ажлын календарчилсан төлөвлгөө гарган ажиллаж байна. 2009 онд иргэнд өмчлүүлэх газрын байршил хэмжээ, зориулалтыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлуулан мөрдөн ажиллаж байна. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш аймгийн хэмжээнд нийт 8208 өрх гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчилж авах хүсэлт гаргаснаас 7467 өрхөд 1258,90 га газрыг өмчлүүлсэн. Үүнээс одоо эзэмшиж байгаа хашааныхаа газрыг өмчилсөн 4292 өрхийн 766.40 га, шинээр газар өмчилсөн 3173 өрхийн 492.4 га, аж ахуйн зориулалтаар газар өмчилсөн 2 иргэн 0.1 га газрыг тус тус эзэлж байна..</p>	50
<p>Нийслэлийг аймгийн төвтэй холбосон улсын чанартай авто замын дагуу тус аймгийн Цэнхэрмандал, Жаргалтхаан, Мөрөн, Хэрлэн сумдууд байдаг бөгөөд улсын чанартай авто замын дагуу өмчлүүлэх газарт хэсэгчилсэн төлөвлөлт хийсний үндсэн дээр газар өмчлүүлэх ажлыг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.</p>	10
<p>Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өссөн дүнгээр 7467 өрхөд 1258.9 га газрыг өмчлүүлсэн бөгөөд тариалангийн болон тариалангийнхаас бусад аж ахуйн зориулалтаар газар өмчлүүлэх ажлыг цаашид зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Хэрлэн сумын Өлзийт тосгонд атаршсан 10000 га тариалангийн талбайг иргэн Баярцэцэг, Биндэр суманд 2179га талбайг “Биндэръяа Буудай” ХХК-д нийт 12179 га талбай дуудлага худалдаагаар эзэмшүүлсэн байна. 2010 онд иргэнд 332.79га, газар тариалангийн зориулалтаар 6401га газрыг эзэмшүүлэхээр төлөвлөөд байна.</p>	10
<p>Монгол Улсын хилийн цэсийн дагуу байрлаж байгаа Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Дадал сумдын улсын хилийн цэсийн эргэлтийн цэгийг GPS-ийн солбицлоор тодорхойлох ажлыг газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас эрх авсан эрх бүхий байгууллагаар хийж гүйцэтгүүлсэн. Одоогийн байдлаар аймаг сумдын хилийн цэсийн эргэлтийн цэгийг дээрхи солбицлын тогтолцоонд тодорхойлох ажил явагдаж байна.</p>	50

<p>2009 онд Дэлгэрхаан сумын соёл, спортын төв, Жаргалтхаан сумын сургуулийн спорт зал , Хэрлэн суманд 920 суудалтай сургууль, Тэмүүжин цогцолбор сургуулийн өргөтгөл,Баянмөнх суманд 75 хүүхдийн, Баян-Адрага, Өмнөдэлгэр суманд 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг тус тус шинээр барьж ашиглалтанд оруулсан бол Өндөрхаан хотын 1 дүгээр сургуулийн дотуур байр, Өмнөдэлгэр сумын ЕБСургууль болон дотуур байрны засвар, Хэрлэн сумын 3-р цэцэрлэгийн сүрлэн барилгын цэвэр, бохир усны холболтын ажил хийлээ. Бор-Өндөр хотын сургуулийн өргөтгөл 6 анги, дотуур байрны өргөтгөл, Баян-Овоо сумын соёлын төв,Батширээт сумын 75 хүүхдийн цэцэрлэг, Биндэр сумын 960 хүүхдийн сургууль, Хэрлэн сумын МСҮТөвийн зэрэг барилга объектын барилга угсралтын ажил хийгдэж байна.</p>	<p>100</p>
<p>2009 онд ХХААХҮЯ-нд шинэчлэлт хийгдэхэд шаардлагатай техникийн захиалгыг өгч ажилласнаар 175м/хүчтэй трактор 3ш, 120 м/хүчтэй трактор 1ш, Т-150 трактор 3ш, хор цацагч 3ш , будаа цэвэрлэгч 1ш, ачигч 1ш, үрлэгч 3ш, дунд оврын трактор 3ш-ийг хөнгөлөлттэй үнээр олгоод байна. Аймгийн тариаланчдын зөвлөгөөнөөр тариаланчдын гаргасан саналыг үндэслэж, аймгийн Засаг даргын шийдвэрээр " Тариаланг дэмжих сан"-г байгуулж 20тн санте сортын төмсний үрийг худалдан авахад шаардагдах 16.0 сая төгрөг, төмс, хүнсний ногоо тариалж байгаа 3 иргэнд үр болон тоног төхөөрөмж худалдан авахад дэмжлэг болгон нийт 15.5 сая төгрөг тус тус олгов.</p>	<p>30</p>
<p>ᠵ ᠣᠶᠢᠣᠶᠤᠳᠦ ᠣᠠᠳᠤᠰᠤᠠᠠ ᠣᠠᠶᠢᠠᠠᠨ ᠴᠢᠳᠡᠳᠡᠭᠡ</p>	
<p>Өндөрхаан хотын цэвэрлэх байгууламжид технологийн шинэчлэл хийгдээгүй, харин Бэрх тосгоны цэвэрлэх байгууламж эвдэрч ашиглагдахгүй болсныг хүн мал орохоос сэргийлж хамгаалалт хийгээд байна. 2010 оны хөрөнгө оруулалтад зураг төсөв хийх хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох газарт санал хүргүүлээд байна.</p>	<p>10</p>
	<p>хугацаа болоогүй</p>
	<p>хугацаа болоогүй</p>

<p>Онон голын сав газрын зөвлөлийг аймгийн ИТХТ-ийн 2009 оны 108 тоот тогтоолоор 14 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж үйл ажиллагааг нь эхлүүлээд байна. 2009 оны 10 сард Дадал суманд дээрх сав газрын зөвлөлийн хурлыг зохион байгуулж, бүтэц зохион байгуулалтын асуудлаа хэлэлцэж баталсан байна. Мөн Хэрлэн голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийг боловсруулж байгаатай холбогдуулан Усны төвд саналаа хүргүүлсэн.</p>	50
<p>Одоогийн байдлаар 17 суманд гар худаг сэргээн засварлах, хадлангийн газар хаших хадлан авах зэрэг ажлыг тогтвортой амьжиргаа-2 төслийн хүрээнд хэрэгжүүлж эхлээд байна. Цэнхэрмандал суманд 2009 онд ХЯБХөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар 13.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хөв байгуулагдсан. Мөн Цэнхэрмандал суманд 150.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Түлүүгийн буланд хөв байгуулах ажил хийгдэж байна.</p>	30
<p>2009 оны эхний улиралд Ойн тухай хууль болон Байгаль орчны сайдын 2009 оны 01 тоот албан даалгаврын дагуу "Бүх нийтээр мод тарих өдөр"-ийг зохион байгуулж дараахь арга хэмжээг авч ажиллаа:1.Аймгийн хэмжээнд жил бүр мод тарих хөдөлгөөнийг зохион байгуулахтай холбогдуулан Бүх нийтээр мод тарих сарын ажлil, аймгийн хэмжээнд бүх нийтээр мод тарих сарын ажлын хүрээнд тарих модны доод хязгаар, нэг модны үнэ,нэг мод тарьж ургуулах зардал зэргийг тооцож аймгийн Засаг даргын 2009 оны 139 дүгээр захирамжаар баталгаажуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллаа.</p> <p>2. БОАЖГазраас сум дүүргийн Засаг дарга нарт мэргэжлийн зөвлөлгөө өгч,мод тарих арга технологийг харуулсан мэдээлэл өгсний зэрэгцээ 1800 уут мандлын цэцгийн үр тарааж 85 мандал шинээр байгуулж 130кв.м талбайг шинээр зүлэгжүүлэх ажлынг зохион байгуулж явцад мэргэжлийн хяналт тавьж үр дүнг тооцож хамтарч ажиллаа.</p>	

<p>3.Аймгийн хэмжээнд Өндөрхаан хотод нарс, гүйлс, шар хуайс, чацаргана, мойл, хайлаас зэрэг мод бутны үзэсгэлэн худалдааг 3 хоног зохион байгуулж энэ ажилд мод бут тарьж үржүүлдэг 1аж ахуйн нэгж , 5 иргэд оролцож өөрийн тарьсан модоо худалдаж борлууллаа.</p> <p>Аймгийн хэмжээнд гүйлс-17800, хайлаас 16078, нарс-175, шинэс-127,гацуур-25,чацаргана 7670,үхрийн нүд 4000, улиас-1324,бургас-5, шар хуайс-1500, монос-20, нохойн хошуу-100 ширхэг айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагууд тарьсан. 2009 онд улсын төсвийн хөрөнгөөр 377 га талбайд ойжуулалт, байгалийн сэргэн ургалтанд туслах ажлыг эхэлснээс Дадал суманд 117 га, Өмнөдэлгэр суманд 40 га Батширээт суманд 60 га, Биндэр суманд 40 га талбайд тус тус ойжуулалтын ажил, байгалийн сэргэн ургалтанд туслах ажлыг Батширээт, Биндэр суманд тус тус 50 га талбайд хийж дуусаад улсын комисс хүлээн аваад байна. Уг ажилд нийт 49.5 сая төгрөг зарцуулагдаад байна.</p>	50
<p>Бэлчээрийн менежмент болон бэлчээрийг нөхөн сэргээх, хашиж хамгаалах чиглэлээр Тогтвортой амьжиргаа -2 төсөлтэй хамтран 17 сумын 68 хүнийг хамруулсан 2 өдрийн сургалтыг зохион байгуулсан. Уг сургалтаар бэлчээрийг нөхөн сэргээх, хамгаалах, тарималжуулах талаар малчид, мал бүхий иргэдэд мэдээллийг өгсөн ба уг ажилд иргэдийг татан оролцуулах, идэвхийг өрнүүлэх ажлыг зохион байгуулж байна. Малчид иргэдийн оролцоотойгоор 2009 онд аймгийн хэмжээнд нийт 38 энгийн уурхайн худаг гаргаж 76000 га бэлчээрийг нэмж усжуулсан байна. Мөн Улсын төвсийн хөрөнгөөр Биндэр, Норовлин, Батноров, Батширээт сумдад нийт 4 булгийг эхийг хашиж хамгаалан нийт 6.0 сая төгрөгийг зарцуулсан байна.</p>	30
<p>Хэрлэн голын эрэг дагуу тариалалт явуулдаг "Арт маргад"ХХК нь 100 га талбайн захаар цөлжилтөөс хамгаалах, хөрсийг салхины элэгдэл эвдрэлээс хамгаалах зорилгоор үндсэн зурвас байгуулан модны суулгац тарьцыг тарьж суулгасан.</p>	10

<p>Агаарын өвчлөлийн үндэслэлээр 2009 оны 54 дүгээр тогтоолын дагуу Дэлгэрхаан сумын Хэрлэн тооно уул, Дархан сумын Дархан уулуудыг УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛТТАЙ ГАЗРЫН нөөцөд оруулахаар материалыг бүрдүүлж байна. Мөн Мөрөн сумын тусгай хэрэгцээний газрын хилийн заагийг нарийвчлан тогтоож Ашигт малтмал, геологи уул уурхайн газарт хүргүүлээд байна.</p>	50
<p>Аймгийн ИТХ-ын 2008 оны 24-р тогтоолоор Дэлгэрхаан суманд орших Хэрлэн тооно уулын 10962 га, Хөлийн нуурын 378 га, Их хайлантын амны 891 га, Дэлгэр хаан уулын 1089 га, Ханан уулын 617 га, Долоод уулын 1393 га, Сүүжийн талын 1263 га, Замагт нуурын 165 га газруудыг Байгалийн унаган төрхийг хадгалах, зохистой ашиглах, түүхийн үзмэр, үзэсгэлэнт байгалийг түшиглэн аялал жуулчлал хөгжүүлэх зорилгоор аймгийн хамгаалалтанд авсан. Аймгийн хэмжээнд байгалийн үзэсгэлэнт болон түүхийн дурсгалт газраас жуулчдыг аялуулдаг 16 жуулчны баазууд үйл ажиллагаа явуулж байна.</p>	50
<p>2009 онд улсын төсвийн хөрөнгөөр 377 га талбайд ойжуулалт, байгалийн сэргэн ургалтанд туслах ажлыг эхэлснээс Дадал суманд 117 га, Өмнөдэлгэр суманд 40 га Батширээт суманд 60 га, Биндэр суманд 40 га талбайд тус тус ойжуулалтын ажил, байгалийн сэргэн ургалтанд туслах ажлыг Батширээт, Биндэр суманд тус тус 50 га талбайд хийж дуусаад улсын комисс хүлээн аваад байна. Уг ажилд нийт 49.5 сая төгрөг зарцуулагдаад байна. 2009 онд Хэрлэн суманд 5га талбайд үндсэн зурвас байгуулах ажил хийгдэж уг ажлын хүрээнд 1500ширхэг хайлаас, улиасны суулгацыг тарьсан</p>	30
<p>2009 онд ойн санг гэрээгээр эзэмших нөхөрлөл аймгийн хэмжээгээр 7 суманд нийт 56 нөхөрлөл , 3 ААН , 1 ТББ үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна. Хамтын оролцооны ойн менежментийн чадавхийг бэхжүүлэх төсөлтэй хамтран ойн нөхөрлөлүүдэд 17 удаа 174 хүний бүрэлдхүүнтэй сургалтыг зохион байгуулсан. Суралтыг ойн нөхөрлөл байгуулах эрх зүйн үндэслэл, ой зохион байгуулалт, ойн зураг ашиглах арга, хамтын оролцооны арга, ойн арчилгааны огтлол явуулах арга, ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах сургалт, ойн хууль тогтоол, дүрэм, журам гэсэн сэдвээр зохиов. 2009 онд уул уурхайн болон байгаль орчны чиглэлээр давхардсан тоогоор 1169 удаагийн үзлэг шалгалт хийхэд 675 зөрчил илэрсэн байна. Уг зөрчлүүдээс 605 -ыг нь арилгуулж, 6.3 сая төгрөгийн торгууль нөхөн төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.</p>	50

<p>Ховордсон амьтныг хамгаалах ажлыг сайжруулах ажлын хүрээнд нэн ховор амьтан болох аргаль хонины идээшил нутгийг тогтоож мэдээллийн санд оруулсан./GIS-д / Дархан сумын аймгийн хамгаалалттай Дархан уулын ховор амьтадад хужир, шүү, өвс, тэжээл тавьж өгөх ажлын гэрээг БОАЖЯамны Байгаль хамгаалах сантай гэрээ /2009.04.10-ны өдрийн 01 тоот гэрээ/ байгуулж биотехнологийн арга хэмжээ авав.</p>	50
<p>Аймгийн газрын нэгдмэл сангийн тайланг сумдаар нэгтгэн гаргаж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэн ажиллаж байна. Мөн тайлангийн зураглалыг тоон хэлбэрээр болон өөрчлөлтийн тайлбартай нь гаргаж хүргүүлсэн байна.</p>	30
<p>Улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгэн хүлээн авч хэрэгжүүлэн ажиллаж байна.</p>	30
<p>Аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, төлөвлөгөөг шинэчлэх хөгжлийн цогц бодлого, төлөвлөгөөтэй/2009-2021/ уялдуулан 2009-2010 онд хэрэгжүүлэх богино хугацааны ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.</p>	30
<p>Хэнтий аймгийн хэмжээнд Аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор 2009-2010 онд хийх ажлын төлөвлөгөө гарган аймгийнхаа танилцуулга, ном товхимол хийхээр бэлтгэл ажилдаа ороод байна</p>	30

<p>Аймгийнхаа Дадал, Биндэр, Баян-Адрага, Норовлин сумдад үйл ажиллагаа явуулж байгаа Зочид буудал, жуулчны баазуудад шалгалт хийж байршлыг нь тодорхойлж танилцуулгыг гарган жуулчны баазуудын мэдээллийг нэгтгэн аймгийнхаа аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн дэлгэрэнгүй мэдээллийг вэб сайтад байршуулаад байна.</p>	50
<p>Судалгаа хийгдэж байна.</p>	10
<p>Дадал сумын төвд Чингис хааны хөшөө цогцолбор байгуулах төлөвлөгөөг гарган зураг төслийн уралдаан зарлах бэлтгэл ажил хангагдаж байна. 2010 онд Дадал суманд аялал жуулчлалын хөрөнгө оруулагчдын нэгдсэн уулзалт семинарийг хийхээр төлөвлөн ажиллаж байна.</p>	10
<p>2009 оны 9 дүгээр сард аялал жуулчлалын салбарын олон улсын уулзалтыг зохион байгуулахаар төлөвлөн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байсан ч санхүүгийн хүндрэл бэрхшээлээс шалтгаалан тодорхойгүй хугацаагаар хойшлогдоод байна.</p>	10
<p>2009 онд ойн санг гэрээгээр эзэмших нөхөрлөл аймгийн хэмжээгээр 7 суманд нийт 56 нөхөрлөл , 3 ААН , 1 ТББ үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна.Биндэр ОЙ ОНӨҮГ-ын газар 171000 нарс,Байгаль хам гаалах холбоо-169200 шинэс,Баргажин байд ХХК 48600 ширхэг нарс, Дэлгэр-Онон нөхөрлөл 76400 нарс, иргэн Д.Оюун-Эрдэнэ 56400 шинэс, иргэн Ганбаатар 116620 шинэс, ДОСАНАР ХХК 36900 шинэсийг нийт 675120 ш модыг тарьцаар Дадал,Өмнөдэлгэр, Биндэр сумдад тус тус тарьсан. Мөн ДОСАНАР ХХК 14000шинэс, Алдар Анд нөхөрлөл 7550 нарс, Нийт 21550 ш модыг Дадал, Баян-Адрага, Норовлин сумдад байгалийн сэргэн ургалтанд туслах ажилд зориулж тарьж ургуулсан. 2009 онд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн 58 өргөдөл ирснээс 7 өргөдөлд дэмжсэн хариу, 51 өргөдөлд татгалзсан хариуг өгч Ашигт малтмалын газарт хүргүүллээ</p>	50

<p>Аеіаеёі Ҷаһаа аадәүі 2009 іі 40-д Ҷаеёёаіаааа аеіаа , Њоіуі Ҷаһаа аадәүі Оаіауі ааҶдүі болон агентлаг, газар, хэлтсийн зохион байгуулалтын аҶдөёеа Ҷаһаеёі ааҶдүі 2008 іі 67- д оіадоііеуі аааоо шинээр болон шинэчлэн баталж, ажлын байрны тодорхойлолтуудыг шинэчлэн мөрдүүлснээр ажил үүргийн давхардал, хийдлийг арилгах, төсвийн зардлыг хэмнэх арга хэмжээ ав- аеёеёаае ааеіа.</p>	<p>100</p>
<p>Төрийн албан тушаал /ажлын байр/-ын чиг үүрүао шинжилгээ, үнэлгээ хийсний үндсэн дээр хүлээх үүрэг, хариуцлагыг нь тодорхой тусгасан ажлын байрны тодорхойлолтыг шинээр боловсруулао аеёуі дүуа 2-д һадаа ааеаооёааааі аеёеёаае Аеіаеёі Ҷаһаа аадәүі Оаіауі ааҶдүі аҶо аеёеёаі аеааі оооааеёоаіу аеёуі ааеёдүі оіаідоіеёіеёооа баталж мөрдүүлүуа ааеіа. Мөн сумдын ЗДТГ-ын дарга нарын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруудж, хэрэгжилтэнд нь хяналт тавин ажиллаж байна..</p>	<p>100</p>
<p>Хэнтий аймгийн төрийн бүх шатны байгууллагууд , төрийн албан хаагчид үйл ажиллагаандаа шударга ёс, ил тод байдлыг эрхэмлэн зөвхөн хууль ёсонд захирагдаж, төрийн албаны болон иргэдийн нийтлэг ашиг сонирхлын төлөө ажиллахаа мэдэгдэж, улсын хэмжээнд анх удаа уриалга гаргалаа. Энэхүү уриалгыг хэрэгжүүлэхийн тулд аймгийн ИТХТ-ээр "Төрийн байгууллагын шударга ёс, ил тод байдлын төлөвлөгөө" -г батлуулан мөрдөж ажиллаж байна. Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд ажиллаж байгаа ТЗАХ болон төсөвт байгууллага, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн удирдлагуудын хөрөнгө орлогын мэдүүлгийг авч АТГ-т хүргүүлэн ажиллаж байна. 2009 онд сум, байгууллагуудын удирдлагуудад 2 удаа сургалт семинар өгч, гарын авлага, сурталчилгааны материалаар хангав. АТГ-ын аймаг хариуцсан ажилтантай байнгын харилцаатай, хамтран ажиллаж байна.</p>	<p>30</p>

<p>2009 оны 6 сард ЗГХЭГ-аас зохион байгуулсан Зүүн бүсийн аймгуудын ЗДТГ-ын ХШҮ-ний асуудал хариуцсан ажилтнуудын сургалт семинар, мөн Удирдлагын академид зохион байгуулсан бүх аймгуудын ХШҮ-ний тасгийн дарга нарын 5 хоногийн сургалтад аймгийн ЗДТГ-ын ХШҮ-ний тасгийн дарга, мэргэжилтнүүдийг хамруулсан.</p>	<p>30</p>
<p>Аймгийн Засаг даргын 2008 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 150 дугаар захирамжаар аймгийн "Багийн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр"-ийг батлан үүнтэй уялдуулан 2008-2010 он хүртэл уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байна. Дэд хөтөлбөрийн хүрээнд тавигдах шалгуур үзүүлэлтэнд нийцсэн Баян-Адрага сумын Жаргалант баг /2/, Батноров сумын Эрдэнэчандмань баг /1/, Баянмөнх сумын Хэрлэн баг /2/, Дархан сумын Хараат /2/ бат, Мөрөн сумын Зөөлөн /1/ баг, Өмнөдэлгэр сумын Баянзүрх /2/ баг Биндэр сумын Баянгол /3/ багийг жишиг баг болгон ард иргэдийн болон төсөл хөтөлбөрийн тусламжтайгаар бүрэн тохижуулан үйл ажиллагаа явуулж байна.Аймгийн "Тэргүүний баг" шалгаруулах болзлыг аймгийн Засаг даргын 2009 оны 312 тоот захирамжаар батлуулан мөрдөж ажиллаж байна.</p>	<p>30</p>
<p>Ä-É ÁÀĒÄÄĒ, ÄÄÄÄÄÄ ÁĪÄĒĪÄŪĪ ÇĪÐĒĒÒ</p>	
<p>. Гадаад бодлого</p>	
<p>ОХУ, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр, Шилийн гол аймгуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллаж байна. 2009 оны 6 сард Өндөрхаан хотноо "Хөлөнбуйрын өдрүүд" нэртэй үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа. Мөн манай аймгийн төлөөлөгчид Хөлөнбуйр аймгийн Хайлаар хотноо болсон ХАА, барилгын материалын үзэсгэлэн худалдаа, ОХУ-ын Өвөр байгалийн муж улсын Чита хотод зохион байгуулсан сибирин шилмэл үүлдрийн малын</p>	

үзэсгэлэн худалдааг үзэж сонирхов.Шилийн гол аймгийн Зүүн үзэмчин хошууны удирдлагууд Өндөрхаан хотноо айлчилж аймгийн удирдлагуудтай уулзаж эдийн засаг, соёл урлаг, боловсрол, аялал жуучлал, спортын чиглэлээр хамтран ажиллах талаар санал солилцлоо. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Зүүн үзэмчин хошууны Улиастай хотын уламжлалт анагаах ухааны эмнэлэг дээр туршлага судлах ажилд аймгийн Эрүүл мэндийн газрын нөхөн үржихүй, эрүүл ахуйн мэргэжилтэн, Мэргэжлийн хяналтын газрын эмчилгээ оншолгооны чанарын улсын байцаагч нар хамрагдлаа. Монгол улс "Гадаад харилцааг эдийн засагжуулах" хөтөлбөрийн төсөлд Япон, Швейцарийн холбооны улс, БНСУ, БНЭнэтхэг улстай хамтын ажиллагаа эхлүүлэх санал хүргүүлээд байна.Мөн Халх голын ялалтын 70 жилийн ойн арга хэмжээг Өндөрхаан хотноо зохион байгуулж, ОХУ-ын зочид төлөөлөгчдийг хүлээн авч, уулзалт хийсэн.

30

2009 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 9/405 албан тоотоор Гадаад харилцааны сайд С.Батболдод Дадал сумын нутаг дахь Агацын гол-Алтаны хилийн боомтыг цаашид ажиллуулах саналтай байгаагаа уламжилсан. Мөн тус яамны Гэрээ, эрх зүйн газарт уг боомтыг ажиллуулах болсон үндэслэл, саналыг 2009 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 9/745 албан тоотоор хүргүүлээд байна. 2009 оны 8 сард Дорнод аймагт зохион байгуулагдсан гадаадын хөрөнгө оруулагчдын зөвлөгөөнд аймгийн Засаг дарга оролцож, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа талаар илтгэл тавьсан.

30

тан хамгаалах бодлого

Батлан хамгаалахын сайдын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу дайчилгааны бэлтгэл нөөцийн 1-р зэргийн үүрэгтний сургалтыг 2009 оны 3 сарын 31-нээс 4 сарын 16-нд Өмнөдэлгэр, Хэрлэн сумдад тус бүр 20 хүнтэйгээр зохион байгуулж явуулсан .

50

ийг арилгах үндэсний чадавхи бэхжүүлэх бодлого

Бор-Өндөр хотод Гал унтраах ангийг байгуулах саналыг хүргүүлснээр ОБЕГ-ын даргын 2008 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 571-р тушаалаар тус тосгонд Гал унтраах ангийг байгуулж 2009 оны 4-р сарын 1-ний өдрөөс эхлэн 43 хүний бүрэлдэхүүнтэйгээр, гал унтраах зориулалт бүхий 2 автомашинтайгаар үйл ажиллагааг явуулж байна. Гал унтраах анги байгуулагдсантай холбогдуулан хуучин байрлаж байсан байрыг сэргээн засварлаж ашиглаж байна.


100


Хугацаа болоогүй

0.394

хэрэгжих
хугацаа

2008-2012





2008-2012

2011-2012

2008-2012

2008-2012

2008-2012

2008-2012

2009-2012

2008-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012




2009-2012

2009-2012
2010-2012

2009-2012

2008-2012

2008-2012



2009-2012

2009-2012

2009-2012


2009-2012

2009-2012

2009-2012

2009-2010

2009-2012




2009-2012

2009-2012





2009-2012



2009-2012

2009-2012





2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012


2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012



2009-2012

2009-2012

2009-2012


2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012



2009-2012
2009-2010
2010-2011
2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012
2009-2012
2009-2012
2009-2015

2009-2012

2009-2012

2009

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2010

2009-2010

2009-2012
2009-2010

2009-2010

2009-2010

2009-2010

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2012

2009-2010

2009-2015

2009-2010

2009-2012

2009-2012

2009-2012
2009-2012
2009-2012
2009-2015

2009-2012

2009-2012

2009-2012

2009
2009-2012
2009-2012

2009
2009-2012
2009-2010

2009-2012
2009

2009-2012

2009-2012

2009-2012

2010-2012
2010-2012